

ЭСКАЛАТОРЫГ ТӨХӨӨРӨМЖЛӨХ, АЮУЛГҮЙ АШИГЛАХ ДҮРЭМ

1. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

- 1.1. Энэхүү дүрэм нь эскалаторыг төхөөрөмжлөх, зураг төсөл зохиох, үйлдвэрлэх, угсрах, хийцийг шинэчлэн өөрчлөх, засварлах, ашиглах үйл ажиллагаанд тавигдах шаардлагыг тогтооно.
- 1.2. Энэхүү дүрэм нь барилгын хонгилын болон давхрын эскалаторт хамаарна.
- 1.3. Энэхүү дүрмийг Монгол Улсын нутаг дэвсгэрт өмчийн хэлбэр харгалзахгүйгээр бүх аж ахуйн нэгж, байгууллага, иргэд нийтээр дагаж мөрдөнө.
- 1.4. Эскалаторын үндсэн нэр, томъёог энэхүү дүрмийн 1 дүгээр хавсралтад үзүүлэв.

2. ЕРӨНХИЙ ШААРДЛАГА

- 2.1. Эскалаторын зураг төсөл зохиох, үйлдвэрлэх, барилга, байгууламжид угсрах, ашиглалтанд оруулах нөхцөл нь энэхүү дүрэм болон “Барилгын норм ба дүрэм”-ийн шаардлагад нийцсэн байна.
- 2.2. Эскалаторын цахилгаан тоноглол, түүний угсралт, цахилгаан хангамж болон газардуулга нь “Цахилгаан байгууламжийн дүрэм” /БД 43-101-03/-ийн шаардлагад бүрэн нийцсэн байх ёстой.
- 2.3. Эскалаторын цахилгаан тоноглолын ашиглалт нь “Хэрэглэгчийн цахилгаан тоног, төхөөрөмжийн техник ашиглалтын дүрэм”, “Цахилгаан байгууламжийн ашиглалтын үед мөрдөх аюулгүй ажиллагааны дүрэм”-ийн шаардлагыг хангасан байх ёстой.
- 2.4. Эскалаторын хийц нь Монгол Улсын галын аюулгүй байдлын тухай хууль, холбогдох норм, дүрмийн шаардлагад нийцсэн байх ёстой.
- 2.5. Гадаад орноос эскалатор худалдан авах байгууллага нь түүнийг нийлүүлэгч улсын /байгууллага, фирм г.м./ “Эскалаторыг төхөөрөмжлөх, аюулгүй ашиглах дүрэм”-нь энэ дүрэмд заасан шаардлагатай нийцэж байгаа эсэхийг мэргэжлийн хяналтын байгууллага, зөвлөх үйлчилгээ үзүүлэгчийн оролцоотойгоор харьцуулалт хийнэ.

Хэрэв эскалаторыг нийлүүлж байгаа улсын норм, дүрэм аюулгүй ажиллагааны шаардлага нь энэхүү дүрэмд зааснаас зөрүүтэй байвал тухайн улсаас эскалатор худалдан авах гэрээг албан ёсны болгохоос өмнө энэ асуудлыг мэргэжлийн хяналтын байгууллага болон зөвлөх үйлчилгээ үзүүлэгчид танилцуулж, зөвшөөрөл авна.

- 2.6. Гадаад оронд үйлдвэрлэгдсэн эскалаторын техникийн баримт бичиг нь монгол эсвэл орос, англи хэлээр бичигдсэн байх ба цахилгааны болон бусад схемийн тэмдэглэгээ нь олон улсын стандартын шаардлагад бүрэн нийцсэн байх ёстой.
- 2.7. Импортоор нийлүүлэгдсэн эскалаторын хийц, үйлдвэрлэлтэй холбогдсон дутагдал, зөрчил илэрсэн тохиолдолд түүнийг үйлдвэрлэгч үндсэн байгууллагад худалдан авсан байгууллагаар дамжуулан хүсэлт, гомдол, шаардлага тавих ёстой.
- 2.8. Эскалатор түүний эд анги, зангилаа нь бат бөхийн болон найдвартай ажиллагааны шаардлагыг хангасан байхаас гадна ашиглалтын үеийн техникийн үзлэг, засвар үйлчилгээ, тосолгоо хийх тохиромжтой нөхцлийг хангасан байна.
- 2.9. Хөдөлгөөнт тавцангийн гинж болон бусад холбоос эд анги тасарч салсан үед эскалаторын хийц нь хөдөлгөөнт тавцангийн геометр хэлбэрийг хадгалсан байна.
- 2.10. Эскалаторын хийц нь орох талбайн өмнөх гишгүүрийн өргөгдөх, буух нөхцлийг

урьдчилан тооцож тоноглогдсон байна.

2.11. Салдаг холболтуудын бэхэлгээ нь ашиглалтын явцад өөрөө суларч, салахаас урьдчилан сэргийлж, бэхлэгдсэн байх ёстой.

2.12. Эскалаторын мушгих момент дамжуулдаг чийрга суулттай холбоос ашигласан үндсэн эд ангиудыг тэвх, боолт гэх мэт нэмэлт бэхэлгээгүйгээр ашиглахыг зөвшөөрөхгүй.

2.13. Эскалаторыг бүрдүүлж буй эд ангиуд нь орчны хэвийн нөхцлийг хангасан байх ба зэврэлтээс хамгаалагдсан байна.

2.14. Эскалаторын эргэлдэж байгаа эд ангийн үл хөдлөх тэнхлэг, тулгуур нь түүнийг хөдөлгөөнгүй байлгах зориулалтын тоноглолоор найдвартай бэхлэгдсэн байх шаардлагатай.

2.15. Эскалаторын хөдөлгөөнтэй одон болон шүдэт араа, татах, дамжуулах гинж, тэвх, боолттой голууд гэх мэт эд ангиуд нь үйлчлэх ажилтны аюулгүй байдал, техникийн үзлэг, засвар үйлчилгээ, тосолгоо, хийх нөхцлийг хангасан битүү хаалттай байна. Зайлшгүй тохиолдолд хаалт, хамгаалалтыг авч, угсардаг хийцтэйгээр хийнэ.

2.16. Эскалаторын техникийн үзлэг, үйлчилгээ хийх болон ажлын механизмууд, цахилгаан тоноглол, ослоос хамгаалах хэрэгслэлүүдэд хүрч үйлчлэхэд аюулгүй ажиллагааны шаардлага хангагдсан байх ёстой. Зайлшгүй тохиолдолд зориулалтын талбай, угсардаг хаалт, хашилт, шат тусгай тоноглолыг хэрэглэвэл зохино.

2.17. Эскалаторын хийцийн гишгүүр эргэж, доош харж байрлах бүсэд механизм, цахилгаан тоноглолуудыг тос, бохир орохоос хамгаалсан тосгуур, тэвш гэх мэт тусгай хамгаалалтуудыг хийнэ.

2.18. Эскалаторын гадна хэсэг, машины болон татан чангалах төхөөрөмжийн өрөөний гэрэлтүүлэг нь эрүүл, ахуйн норм, дүрмийн шаардлагыг хангасан байвал зохино.

2.19. Эскалаторын ашиглалтын болон засвар, техникийн үйлчилгээний баримт бичгийг олон улсын ISO 9001, 14001 стандартын шаардлагын дагуу бүрдүүлсэн байна.

3. ЭСКАЛАТОРЫН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ, ХЭМЖЭЭ , АЧААЛАЛ

3.1. Эскалаторын үндсэн үзүүлэлтүүдийг 2 дугаар хавсралтаар,

3.2. Эскалаторын үндсэн хэмжээ, бүтцийн схемийг 3 дугаар хавсралтын 1 дүгээр зургаар,

3.3. Эскалатор, түүний элементүүдийн тооцоо, туршилтын үед ашиглах үндсэн ачааллыг 4 дүгээр хавсралтаар,

3.4. Даацын металл хийцийн бат бөх болон гулзайлтыг харгалзах ачааллын дагуу шалгах тооцоог 4 дүгээр хавсралтаар тус тус үзүүлэв.

3.5. Бат бөхийн тооцоонд нөөцийн итгэлцүүрийг тооцоходоо эвдлэх хүч ба 4 дүгээр хавсралтад заагдсан тухайн элементэд ачааллын үед үүсэх хамгийн их хүчний харьцаагаар тодорхойлно.

3.6. Татах болон дамжуулах гинжний бат бөхийн нөөцийн итгэлцүүр нь 7-оос багагүй, гишгүүр болон бариулын бат бөхийн нөөцийн итгэлцүүр нь 5-аас багагүй байна.

3.7. Татах гинжний бодит бат бөхийн нөөцийн итгэлцүүрийг тусгай зориулалтын тоноглол дээр шалгана. Үүний тулд 200-аас ихгүй гоццооноос 2-оос доошгүй ижил хэмжээтэйг сонгон чвч эвдэртэл нь туршина. Туршилтын үр дүн энэхүү дүрмийн 3.6-д заасан шаардлагыг хангасан байна.

Туршилтанд оруулахаар сонгож авсан гинжний урт нь 600 мм-ээс багагүй байвал зохино.

Гинжний туршилтыг явуулах үед голын нүхэн дэх гишгүүрийн голтой хамт

байрлуулж туршилтыг явуулна.

Хэрэв гуршилтын ачааллын хэмжээ нь эвдлэх ачааллаас 5%-иас хэтэрвэл заавал эвдэртэл турших шаардлагагүй ба туршилтад тавигдах шаардлагыг хангасанд тооцно.

Гинжний гогцоо бүр нь ашиглалтын ачааллын үе дэх тооцоологдсон таталтын хүчнээс 2 дахин илүү ачааллаар шалгах тоноглол дээр туршигдсан байвал зохино. Туршилтын дараа гинжний гогцоонд үлдэгдэл хэв гажилт үлдээгүй, гинжний эд анги эвдэрч салаагүй байх ёстой.

3.8. Гишгүүрийн бат бөхийн нөөцийн бодит итгэлцүүрийг тусгай тоноглол дээр нэг жилийн дотор, зохион бүтээлтийн нэг техникийн баримт бичгээр, нэг технологиор, нэг үйлдвэрт 10000 нэгжээс илүүгүй тоогоор үйлдвэрлэгдсэн гишгүүрийн 2 голтой загварыг сонгон авч, эвдэртэл нь ачаалж, тодорхойлно. Туршилтын үр дүн энэ дүрмийн 3.6-д заасан шаардлагыг хангасан байна.

Үйлдвэрлэгдсэн болон засварлагдсан гишгүүр нэг бүрийг тусгай тоноглол дээр статик ачааллаар шалгана. Үүнд:

Гишгүүрийн өргөн, мм	Ачаалал, Н
1000	3200
800	2400
600	1600

Эскалаторыг зохион бүтээсэн байгууллагаас гаргасан аргачлалыг дагуу үйлдвэрлэгдсэн бүлэг бүтээгдэхүүн тус бүрээс 2-оос цөөнгүй гишгүүрийг сонгон авч, динамик туршилтанд оруулна.

Динамик туршилт явуулах аргачлалд хөдөлгөөнт тавцангийн дээд муруйлтын хэсэг дээр үүсэх хамгийн их хүчийг тооцсон байх ёстой.

Туршилтын дараа гишгүүрт зураг, төсөлд заасан хэмжээ өөрчлөгдөхгүй, үлдэгдэл хэв гажилт үүсэхгүй байх ёстой.

3.9. Металл хийцийн q_{c2} хүчний үйлчлэлээр гулзайх хэмжээ нь хонгилын эскалаторт 1/1000, давхрын эскалаторт металл хийцийн тулгуур хоорондын зайн 1/750-иас тус тус хэтэрч болохгүй.

3.10. Давхрын хучилтын хавтангийн өөрийн жинг тооцсон гулзайлтын хэмжээ болон барилгын адрын хучилтын хавтан нь q_{c2} хүчний үйлчлэлээр гулзайхдаа алслалтын зайн 1/600-аас хэтэрч болохгүй.

3.11. Муруй шугамын замын хэсэг дахь гулзайлтыг тооцохдоо татах гинжнээс үүсэх нэмэгдэл хүчийг оруулж тооцно. $q_{мэ}$ хүчний үйлчлэл доорхи чиглүүлэгч замын гулзайлтын жэмжээ нь алслалтын зайн 1/1000-аас хэтэрч болохгүй.

3.12. Эскалаторын хашлаганы хормойн уян гулзайлтын хэмжээ нь 0.0025м^2 талбайд перпендикуляр чиглэлээр 1500Н хүчээр үйлчлэхэд тулгуур хооронд 4мм-ээс хэтэрч болохгүй. Үлдэгдэл хэв гажилт үүсэхгүй байх ёстой.

3.13. Ажлын тоормос нь хөдөлгөөнт тавцанг зорчигч хамгийн их ачаалалтай $\{q_m\}$ үед 2-оос багагүй дахин их нөөцийн тоормосны моментоор барина.

3.14. Хоёр болон түүнээс олон тоотой ажлын тоормос хэрэглэсэн тохиолдолд хөдөлгөөнт тавцанг хамгийн их ачааллын үед тус бүр нь 1.1 дахинаас багагүй нөөцийн тоормосны моментоор барихаар тооцогдсон байх ёстой.

3.15. Бариулын бодит нөөцийн итгэлзүүрийг үйлдвэрлэгч нь шалгаж, тодорхойлно. Ачааллыг 4 дүгээр хавсралтад заасны дагуу тооцно. Бариулыг үйлдвэрлэсэн үйлдвэрээс нь паспортын нь хамт нийлүүлнэ.

4. ОНЦГОЙ ХИЙЦ БҮТЭЭЦИЙН ГАГНУУРЫН МАТЕРИАЛУУД. ГАГНУУР, ТҮҮНИЙ ЧАНАРТ ТАВИХ ХЯНАЛТ

4.1. Эскалаторын онцгой хийц бүтээцийн гагнуурын элемент, эд анги, хийцийг үйлдвэрлэх, засварлах зориулалтын үндсэн болон гагнуурын материалыг сонгохдоо тусгай зөвшөөрөл бүхий байгууллагын боловсруулсан гагнуурын ган хийцийг сонгох зааврын дагуу ашиглалтын үеийн орчны температурын нөхцөл, тээвэрлэлт болон тоног төхөөрөмжийн угсралтыг тооцож сонгоно.

Онцгой хийц бүтээцэд дараах эд ангиуд хамаарна. Үүнд :

- гишгүүр
- машины өрөөнд байрлах өргөх байгууламжийн хийц орох авцан
- арал ба хучилтын хавтан, тэдгээрийн тулгуурууд
- хөдөлгөөнт тавцангийн чиглүүлэгч зам
- тоормосны суурийн арал, хөшүүргүүд
- бүсүүдийн металл хийцүүд
- засвар, техникийн үйлчилгээний талбай болон хаалт, хамгаалалтын тусгай хийцүүд

Эскалаторын гагнуурын тооцооны бүрэлдэхүүн хэсэг тус бүрийг техникийн баримт бичигт тусгана.

4.2. Хэрэглэгдэж буй стандартын металлыг нийлүүлэгч үйлдвэрийн гэрчилгээ, металлын шинжилгээ, туршилтын үндсэн дээр баталгаажуулна.

4.3. Гагнуурын технологийг эскалаторын үйлдвэрлэл, шинэчлэлт өөрчлөлт эсвэл засвар хийж байгаа болон гагнуурын чиглэлээр дагнан мэргэшсэн тусгай зөвшөөрөл бүхий байгууллага боловсруулна. 10мм-ээс илүү зузаантай даацын зангилаанд гагнуур хийсний дараа дулааны боловсруулалтыг шаардлагатай тохиолдолд хийвэл зохино.

4.4. Эскалаторын онцгой хийц, бүтээцийн гагнуурыг Дэд бүтцийн хөгжлийн сайдын 1999 оны 164 тоот тушаалаар баталсан “Гагнуурчдыг мэргэшүүлж, эрх олгох дүрэм”-ийн дагуу аттестатчилагдсан гагнуурчнаар гүйцэтгүүлнэ.

4.5. Эскалаторын онцгой хийц бүтээцийн гагнуур хийхэд шаардагдах материал, металлын оёдол, гагнаасан холбооны механик шинж чанар нь үндсэн металл хийцийн гангийн стандарт, бат бөхийн нөөцийн хязгаар, урсалтын хязгаар, харьцангуй уртсалт,

цохилтын зунгааралт зэрэг техникийн нөхцлөөс багагүй байх шаардлагыг хангасан байвал зохино.

Ижил бус маркийн гангаар хийгдсэн даацын металл хийцүүдийг холбож гагнахад хайлах металлын механик шинж чанар нь үндсэн металл хийцийн бат бөхийн хамгийн дээд хязгаартай дүйцэж байх шаардлагыг хангасан байх ёстой.

4.6. Эскалаторыг үйлдвэрлэх, шинэчлэх, засварлахад хэрэглэгддэг гагнуурын электродны төрөл, чанаржуулагч металлын марк, флюс болон хамгаалалтын хийн талаарх тодорхой мэдээллийг зохион бүтээх болон технологийн баримт бичигт заасан байна.

4.7. Угсралтын гагнуурыг хийхдээ технологийн картад заагдсан гагнуур хийх эрх бүхий гагнуурчин энэ ажлыг хийж гүйцэтгэнэ.

4.8. Онцгой хийц, бүтээцийн гагнуурыг хийсэн тусгай пайзтай байх ёстой.

Пайзан дээр гагнуурчны овог, нэрийг бичсэн байна, Мөн гагнуурын ажлыг хүлээж авсан чанарын хяналтын хэлтсийн мастерын пайз байна. Олон гагнуурчин оролцсон бол гагнуурчин тус бүрийн пайзыг оёдлын эхлэл, төгсгөл бүрт байрлуулах ба харин гагнуурыг бригадаар гүйцэтгэсэн бол бригадын даргын пайзыг тавина.

Эскалаторын ашиглалтын явцад гагнуурын холболтын пайз нь муудаж, алга болохооргүйгээр хийгдсэн байна. Пайзыг хийсэн аргачлал, пайзны байрлалыг зураг төсөлд тусгасан байна.

4.9. Эскалаторыг үйлдвэрлэх, шинэчлэн сайжруулах, засварын үед техникийн хяналтын хэлтэс болон түүнтэй адилтгах алба, зөвлөх үйлчилгээ үзүүлэгч этгээд нь гагнуурын оёдлын чанарыг дараах байдлаар шалгана. Үүнд:

а/ гадна үзлэг;

б/ радиографикийн юмуу хэт нам авианы арга;

в/сонгож авсан бэлдцийн механик туршилт;

г/ мэргэжлийн хяналтын байгууллага, зөвлөх үйлчилгээ үзүүлэгч этгээдтэй зөвшилцсөний үндсэн дээр гүйцэтгэх үл эвдлэх туршилт зэрэг болно.

Гагнуурын оёдлын чанарыг шалгасан үр дүнг эскалаторын паспорт дээр бичсэн байна.

4.10. Гагнуурын оёдлын гадна үзлэг, хэмжилтийн үед энэ дүрмийн 4.15.,4.16-д заасан гэм согог илрэхгүй байх ёстой.

Үзлэг, хэмжилтийг 10 дахин өсгөх хараа зүйн багажаар явуулна.

Хэрвээ гагнуурын оёдлын дотор гадаргуу нь харагдахгүй байвал үзлэгийг зөвхөн гадна талаас нь явуулна. Гадна үзлэг, хэмжилтийн үр дүнгээр акт үйлдэнэ.

4.11. Радиографикийн эсвэл хэт нам авианы аргаар болон бусад аргаар шалгахдаа гагнуурын холболтуудыг бүрэн хэмжээгээр нь хамруулна. Оёдлын чанарын талаарх хавсралт нь зохион бүтээх баримт бичигт тусгагдсан байна.

4.12. Цэгэн гагнуурын оёдлын механик шинж чанарыг шалгахдаа технологийн дээж авах аргыгхэрэглэнэ.

4.13. Гагнуурын оёдлын чанарыг гадна үзлэг, хэмжилт, радиографикийн, хэт нам авианы болон бусад арга, бэлдцийн механик туршилтаар шалгасан дүн нь гэмтэл согогтой бүтээгдэхүүн гаргахгүй, гагнуурын холболтын норм, ашиглалтын үеийн бат бөх, найдвартай ажиллагааг бууруулахааргүй, төхнийн баримт бичигт заасны дагуу үр дүнг хангасан байх ёстой.

4.14. Гагнуурын оёдлын гэм согогийг тодорхойлох болон нэр томъёог стандартын дагуу тогтооно.

4.15. Нуман гагнуурын холболтонд дараах гэм согог байхыг зөвшөөрөхгүй. Үүнд:

- ан, цав,
- түлэгдэлт,
- дутуу гагналт,
- овооролт,

үндсэн металлын гагнагдаагүй хэрчлээсний хэмжээ нь гүнээрээ 0.5 мм-ээс их, уртаараа 20 мм-ээс их, оёдлын нийт ургынхаа 10%-иас их байх,

Нуман гагнуураар холбох металлуудыг тулгаж гагнах үед үүсэх нүх, сүв, шаарга нь 20 мм хүртэл зузаантай металлд 1.0 мм-ээс ихгүй, 20 мм-ээс зузаан металлд үндсэн металлынхаа зузааны 5%-иас ихгүй байна. Мөн 200 мм-ийн урттай оёдолд хоорондоо 50 мм-ээс ойрхон хоёроос илүү согог байхыг зөвшөөрөхгүй.

4.16. Цэгэн гагнуурын холболтод дараах гэм согог байхыг зөвшөөрөхгүй. Үүнд:

- түлэгдэлт;
- ан цав;
- дутуу гагналт;
- цэгэн гагнуурын алхам алдагдах, цэгийн тэнхлэг, байрлалыг алдагдуулах хэмжээнд диаметрийг ихэсгэх
- цэгэн гагнуурын диаметр 25%-иас их хэмжээгээр багасах,
- гадна, дотор сагалт

Электродоос үүсэх гүн нь хэрэв нэг цэгт гагнасан бол металлын зузааны 25%-иас, олон цэгт гагнасан бол металлын зузааны 20%-иас хэтрэхийг зөвшөөрөхгүй. Янз бүрийн зузаантай металлуудыг гагнах үед үйлчлэх гүний хэмжээг нимгэн металлынхаар тодорхойлно.

Гэм согогтой гагнуурын цэг нь оёдлын эхлэл төгсгөл дээр байрлаагүй, нийт оёдлын уртын 5%-иас хэтрээгүй болон гэм согогтой цэгийн хооронд 5-аас доошгүй чанартай цэг байх тохиолдолд гагнуурыг чанартайд тооцож, зөвшөөрнө.

Нэг гагнуурын холболт дээр гэм согогтой засварлагдах цэг 25%-иас хэтэрч болохгүй.

4.17. Эскалаторыг үйлдвэрлэх, шинэчлэлт болон засвар хийх үед техникийн нөхцлөөр тогтоогдсон гагнуурын нормоос хэтэрсэн бусад гэм согогийг зөвшөөрөхгүй.

4.18. Механик туршилтыг явуулахдаа гагнуурын оёдлын бат бөх, уян харимхай чанарыг үндсэн болон дагалдах металлууд, гагнуурын горим, оёдол зэрэг үйлдвэрлэлийн ижил нөхцөлд гагнасан туршилтын загвар дээр явуулна.

Механик туршилтын үечилсэн хугацааг эскалатор үйлдвэрлэх тусгай зөвшөөрөлд хяналт тавьж буй мэргэжлийн хяналтын байгууллага тогтооно.

Эскалаторын металл хийцийг гагнахад оролцсон гагнуурчин бүр хяналтын загварыг гагнаж, шалгуулах ёстой.

4.19. Гагнуурын чанарыг шалгах механик туршилтад орох хяналтын загвар нь гагнуурын холболтын төрлөөс үл хамааран тулгаж гагнах ба сунах, гулзайлгах хүчний үйлчлэлээр шалгана. Загваруудыг стандартад заасны дагуу бэлтгэнэ.

Механик туршилтын үр дүнг дараах тохиолдолд тэнцсэн гэж үзнэ. Үүнд:

а/ Гулзайх өнцөг, гагнуурын оёдлын агшин зуурын эсэргүүцлийн доод хязгаар нь тухайн маркийн гангийн стандартын хэмжээнээс багагүй;

б/ Нугалах өнцөг 100°-аас багагүй;

Механик чанарын эдгээр үзүүлэлтүүдийг дундаж гэж тооцно. Туршилтын дундаж үр дүн хангагдсан тохиолдолд зарим загварын хувьд заагдсан үзүүлэлтүүдийг 10%-иас ихгүйгээр бууруулна.

4.20. Гагнуурын холболтын чанарын шалгалтын явцад илэрсэн оёдлын гэм согогийг үйлдвэрлэгч буюу засвар хийж буй байгууллага хариуцан арилгаж, дахин шалгана.

4.21. Эскалаторыг үйлдвэрлэх, шинэчлэлт хийх, засварлах явцад энэ дүрэм, техникийн нөхцлийн дагуу тогтоогдсон нормын хязгаараас хэтэрсэн нь аливаа нэг шалгалтын үед илэрсэн тохиолдолд гагнуурын холболтын чанарыг хангалтгүй болсон гэж үзнэ.

5. ЭСКАЛАТОРЫН ТОНОГЛОЛУУД

5.1. Дамжуулга

5.1.1. Эскалаторын ерөнхий дамжуулга нь 2 дугаар хавсралтад заасан ашиглалтын хурдаар хөдөлгөөнт тавцанг хөдөлгөөнд оруулах үүрэгтэй.

5.2. Тоормосны систем

5.2.1. Эскалаторын дамжуулга нь ажлын тоормосоор тоноглогдсон байна.

5.2.2. Ажлын тоормос нь байнгын бариатай хийцтэй байх бөгөөд редукторын орох гол дээр байрлана.

5.2.3. Ажлын тоормос нь дамжуулга зогсох, удирдлагын цахилгаан хэлхээний гүйдэл тасрах үед энэхүү дүрмийн 3.13-т заасан шаардлагыг хангаж ажиллана.

5.2.4. Эскалаторын ачаалаагүй сул үеийн тоормосны замын уртыг зураг төслийн байгууллага нь 2 дугаар хавсралтад заасны дагуу тоормосны удаашралт, түүний барих

хугацаа ба моментыг нөөцийн итгэлцүүрийг оруулж тооцно. Тохируулгын зай хэмжээ нь 200 мм-ээс багагүй байна.

5.2.5. Тоормосны эд ангийг солих тохиолдолд түүний ажиллах чадварыг ашиглалтын зааврын дагуу шалгах ба энэ тухай эскалаторын паспортад заавал бичнэ.

5.3. Хөдөлгөөнт тавцан

5.3.1. Гишгүүрийн ажлын гадаргуу нь эскалаторын тэнхлэгийн дагуу төвгөр ба хотгоруудтай байх бөгөөд хашлаганы хормойн ирмэгээр хязгаарлагдана. Хашлаганы хормойд шүргэх хоёр захын гадаргуу нь ялгагдах хурц өнгийн будгаар будагдсан байна.

5.3.2. Гишгүүрийн нүүр ба ажлын гадаргуугийн төвгөр, хотгорууд нь хөдөлгөөний үед хоорондоо зохицон байрлана.

5.3.3. Хөдөлгөөнт тавцанг байнга жигд татах зорилгоор татан чангалах тоноглолыг төлөвлөсөн байна.

5.4. Орох талбай

5.4.1. Эскалаторын хөдөлгөөнт тавцанд орох, гарах үеийн аюулгүй ажиллагааг хангах зорилгоор орох талбайг налуу шүдэт ирмэгээр тоногдсон байна.

Орох талбайн гадаргуу нь зорчигчийн гутал хальтрахааргүй хийц бүхий биржгэр гадаргуутай байна.

5.4.2. Орох талбайн шүдэт ирмэгийг сольж болох хийцтэй хийнэ.

5.4.3. Орох талбайн хийц нь түүний доогуур гадны биет орсон тохиолдолд эскалаторыг зогсоох боломжтой нөхцлийг хангасан байна.

5.4.4. Орох талбайн хийц нь гишгүүрийн гадаргууг шүдэт ирмэгтэй зөв чиглүүлэх тоноглолтой байна.

Энэ үед гишгүүрийн гадаргуугийн товгор хэсэг орох талбайн шүдэт ирмэгийн шүдний хоорондуур харилцан шүргэлцэлгүй хөдөлж шилжинэ. Шүдэт ирмэгийн шүдний үзүүр нь гишгүүрийн ажлын гадаргуугийн товгороос доош түвшинд дугуйрсан хэлбэртэй байна.

5.4.5. Орох талбайн гэрэлтүүлэг 50 ЛК-ээс багагүй байна.

5.5. Гишгүүрийн чиглүүлэгч дугуй ба татан чангалах төхөөрөмж

5.5.1. Хөдөлгөөнт тавцангийн татан чангалах төхөөрөмжийн хийц нь эскалаторын тэнхлэгийн дагуу татах одон арааг чөлөөтэй шилжих болон татан чангалах төхөөрөмжийн хоригийн ажиллах боломжийг хангасан байна.

Чиглүүлэгч ба замын дагуу тулгаж бэхлэгдсэн хэсгүүд нь хөндлөн шилжилтээс урьдчилан хамгаалагдсан байна.

5.5.2. Чиглүүлэгч нь зорчигчийн бүсэд гишгүүрийн дараах байрлалыг хангасан замтай байна. Үүнд:

а/ Гишгүүрийн ажлын гадаргуу нь орох талбайгаас гарах талбайн хүртэл бүх замын туршид хэвтээ байрлалыг хадгална. Гишгүүрийн гадаргуугийн налалтын зөвшөөрөгдөх хэргээ нь 1:100-аас хэтрэхгүй байна.

б/ Хөдөлгөөнт тавцангийн орох талбайн өмнө байрлах хэвтээ хэсгийн уртын хэмжээ 3 дугаар хавсралтад зааснаас багагүй байна.

Хэвтээ чиглэлд байрласан дараалсан 2 гишгүүрийн өндрийн зөрөө нь 4 мм-ээс илүүгүй байхыг зөвшөөрнө.

в/ Орох талбайн өмнөх хэвтээ хэсгийн гишгүүрүүд түүний дараагийн налуу хэсгийн эхний гишгүүр хоёрын түвшингийн зөрүү хонгилын эскалаторт 30 мм, давхрын эскалаторт 50 мм-ээс хэтэрч болохгүй.

5.6. Хашлага

5.6.1. Хөдөлгөөнт тавцан ба бариул нь эскалаторын металл хийц болон механизмуудаас бөх бат, хатуу, гөлгөр, галд тэсвэртэй хашлагаар тусгаарлагдсан байх ёстой.

5.6.2. Хашлагын хийц хэсгүүд нь засвар, техникийн үйлчилгээ хийгдэх зориулалтын багаж хэрэгслүүдийн тусламжтайгаар хялбар задарч, угсрагддаг байна.

5.6.3. Хашлага нь босоо, хавтгайнуудаас бүрдэх бөгөөд дээд хэсэгтээ бариул суух зориулалтаар өргөссөн хэлбэртэй байна. Хашлаганы босоо хавтгайнуудын хоорондын зай нь хонгилын эскалаторын хувьд шатны өргөнөөс 200 мм-ээс илүү байх ёстой. Харин давхрын эскалаторын хувьд 100 мм-ээс багагүй хэмжээгээр илүү өргөнтэй байх ёстой.

5.6.4. Хашлаганы босоо хаалт, даруулга, бэхэлгээ зэрэг элементүүдийн хоорондын хавтгай гадаргуу дахь түвшингийн зөрүү нь хөдөлгөөнт тавцан талаасаа 3 мм-ээс илүү байхыг хориглоно.

5.6.5. Хашлаганы хормой нь хормойн босоо уулзварыг зохицуулж байгаа хэсгээс бусад хэсэгт 0.5 мм-ээс илүү түвшингийн зөрүүтэй байж болохгүй ба харилцан шилжиж, хөдлөх боломжгүй байх ёстой.

5.6.6. Хормойн шат луу хандсан гадаргуу нь зорчигчдын гутлыг тээглүүлэхгүй нөхцлийг хангасан байх ёстой. Хормой дээр хөдөлгөөнт тавцан луу хандсан даруулга, бэхэлгээ байрлуулахыг хориглоно. Хашлаганы босоо хавтгай самбар ба хормойн уулзварын хоорондын зай нь 4 мм-ээс илүүгүй байх ёстой.

5.6.7. Эскалаторын зураг төслийг зохиогчийн зөвшөөрлөөр хашлаганы босоо самбартай харьцангуй хөдөлгөөнгүй байрлах хэвтээ гадаргуу дээр чанга яригч, гэрэлтүүлэг болон цахилгаан залгуур байрлуулж болно.

5.7. Бариул

5.7.1. Эскалаторын 2 талаар хашлага дээр хөдөлгөөнтэй бариул угсрагдсан байх ёстой.

5.7.2. Бариулын хурд нь шатны хурдны 2 хувиас илүү зөрүүтэй байж болохгүй.

5.8. Ослоос хамгаалах хоригийн төхөөрөмж

5.8.1. Эскалатор нь дараах тохиолдолд шатны хөдөлгөөнт тавцангийн хөдөлгүүрийг зогсоодог төхөөрөмжөөр тоноглогдсон байх ёстой. Үүнд:

- бариул тасрах, хэт чангарах, эсвэл зогсох тохиолдолд;
- татан чангалах төхөөрөмжийн тэргэнцэр нь дамжуулга эсвэл түүний эсрэг тал руу нь 30 мм-ээс илүү шилжсэн байвал;
- ажлын тоормос ажиллаж эхэлвэл;
- ажлын цахилгаан тоормосны зүрхэвчийн явалтын зай тогтоосон хэмжээнээс багассан тохиолдолд;
- орох талбайн таг өргөгдсөн тохиолдолд;
- “зогс” товчлуурыг ажилласан тохиолдолд;
- шатны орох талбайн өмнө шат өргөгдөх буюу доошлох тохиолдолд;
- бариул нь доод муруйлтын хэсгээс хэвтээ чиглэлд шилжин орох үед гадны биет хавчуулагдсан тохиолдолд;
- давхрын эскалаторт орох талбайн тагийг онгойлгож засварын ажил хийх үед эскалаторыг шалгалтын горимд ажиллуулах бололцоог хангах гар удирдлагаар удирдахаас бусад тохиолдолд;
- гинжин дамжуулга тасрах, эсвэл хэт чангарах тохиолдолд;

Хоригуудын аль нэг ажилласны дараа шалтгааныг арилгаж, төгсгөлийн унтраалгуудыг эхний байрлалд буцаан байрлуулахад эскалатор хэвийн ажиллана.

5.8.2. Эскалаторын дээд ба доод хэсэгт шаардлагатай тохиолдолд зогсоох, “зогс” гэсэн үл буцах ажиллагаатай товчлуурыг заавал суурилуулж өгөх ёстой.

Энэ тохиолдолд аль нэгэн хориг ажилласнаас эскалаторыг зогсоовол түүний тухай мэдээлэл өгөх дохиолол ажиллана.

5.8.3. Аль ч удирдлагын пультээс зорчигчтой эскалаторыг эсрэг чиглэлд залгах боломжгүй байх нөхцлийг хангасан байна.

5.9. Удирдлагын аппарат

5.9.1. Эскалаторын удирдлагын систем нь зорчигчдын ачааллаас хамаарахгүйгээр 2 дугаар хавсралтад заасан эхлэлтийн жигд хурдатгалыг хангах ёстой.

5.9.2. Эскалаторыг ажиллуулах, мөн зогсоохын тулд дээд доод орох талбайд зөвхөн үйлчлэх ажилтан ажиллуулах боломжтой удирдлагын пультаг байрлуулна.

Эскалатор нь алсын зайн удирдлагатай байж болно.

Хонгилын эскалаторт зорчигчдыг бүрэн хянах боломжоор хангагдсан, эсвэл радиогоор анхааруулах бололцоотой тохиолдолд зорчигчидтой эскалаторыг холын зайнаас удирдан ажиллуулж болно.

5.9.3. Эскалаторыг автоматаар ажиллуулж, зогсоох төхөөрөмж, мөн түүнчлэн телемеханик ба теле хяналтын системээр тоноглож болно.

5.9.4. Эскалаторыг засварын горимд удирдахын тулд дараах зүйлүүдийг урьдчилан төлөвлөсөн байх ёстой. Үүнд:

а/ удирдлагын суурин пультуудыг машины болон татан чангалагчийн өрөөнд байрлуулах.

б/ зөөврийн удирдлагын пульт, түүний цахилгааны залгууруудыг холбогдох нөхцлийг бүрдүүлсэн байна.

5.9.5. Удирдлагын зөөврийн пультын залгуур нь дамжуулгын болон татан чангалах төхөөрөмжийн өрөөнд байрлана. Харин хонгилын эскалаторын хувьд хоорондоо 20м тутамд хашлаганы аль боломжтой талд байрлуулна.

5.9.6. Зөөврийн удирдлагын товчлуурууд нь санаандгүй байдлаар залгагдах боломжгүй байх ёстой. Эскалатор нь зөвхөн тусгай түлхүүрээр нэмэлт контактыг залгасны дараа товчлуурыг дарсан тохиолдолд ажиллана. Зөөврийн удирдлага нь “зогс” ба “дээш”, “доош” гэсэн чиглэлийг заах товчлууруудаар тоноглогдсон байна.

6. ЭСКАЛАТОРЫН ӨРӨӨ БА ЭСКАЛАТОРЫГ ТӨХӨӨРӨМЖЛӨХ

6.1. Барилгын хийц нь эскалаторын зорчигчтой үеийн ачааллыг тооцсон байна. Эскалатор суурилагдаж байгаа барилга, байгууламжийн хучилтын хийц нь угсралт, зөөвөрлөлт ба эскалаторын зангилаанаас ирэх ачааллыг тооцсон байх ёстой.

Эскалаторыг суурилуулах барилгын хийц, ханын бэхэлгээний зургийн даалгаварт хийцийг төлөвлөх, тооцоо хийхэд шаардлагатай төвлөрсөн болон тархмал ачааны хэмжээ гэх мэт мэдээлэл агуулагдсан байх ёстой.

6.2. Хонгилын эскалатор суурилагдах барилга нь түүний угсралт, задаргаа хийх, мөн эскалаторын зангилаануудад засвар, техникийн үйлчилгээ хийх боломжтой зай, хэмжээтэй байх ёстой. Дараах зүйлүүдийг урьдчилан тооцсон байна. Үүнд:

а/ дамжуулгыг байрлуулах байр буюу машины өрөө, цахилгаан тоноглол, телемеханик болон удирдлагын аппаратууд;

б/ татан чангалах төхөөрөмжийн өрөө;

в/ эскалаторын налуу хэсгийн үйлчилгээг хийх зориулалт бүхий гарцууд ийм гарц байхгүй тохиолдолд шатны болон хашлаганы завсраар үйлчилгээ хийх боломжтой байх;

г/ Задаргаа хийх хонгил болон орц, гарц;

Шаардлагатай үед эскалаторын засвар, техникийн үйлчилгээ хийх боломжийг хангахын тулд машины өрөөний хажууд жижүүрийн ажилтнуудын байрлах эрүүл ахуйн нормыг хангасан, сэлбэг хэрэгсэл, тослогооны болон бусад материал, хадгалах өрөө, засвар хийх зориулалтын байр зэргийг төлөвлөнө.

6.3. Давхрын эскалаторын хийц нь эскалаторын бүрэлдэхүүн хэсэг, хөдөлгөөнт тавцан,

хашлага болон хучилтын хавтангийн зай завсрыг ашиглан засвар техникийн үйлчилгээ, угсралт, задаргаа хийх боломжтой байх ёстой.

6.4. Хонгилын эскалаторын суурь буюу дамжуулгын илүү гарсан хэсгүүд ба машины өрөөний хана хоорондын өргөн, татан чангалах төхөөрөмж болон хана хоорондын зай нь угсралт, задаргаа хийхэд нийцсэн 900 мм-ээс багагүй хэмжээтэй байх ёстой.

Зорчигчийг 7 метр хүртэл өндөрт тээвэрлэх тохиолдолд машины өрөөний гарцын өргөнийг 600мм хүртэл багасгаж болно.

6.5. Хонгилын эскалаторын дамжуулгын механизм, татан чангалах төхөөрөмж байрласан шалнаас таазны дам нуруу эсвэл таазанд байрласан өргөх механизмын зам хүртэлх зай нь дамжуулгын механизм байрласан шалнаас 2400 мм, татан чангалах төхөөрөмжийн хувьд 2000 мм-ээс тус тус багагүй байх ёстой.

6.6. Зэргэлдээ эскалаторуудын илүү гарсан хэсэг болон тэдгээрийн хайсны хооронд түүнчлэн захын эскалаторын хажуугийн гарцын өргөн нь 500 мм-ээс, өндөр нь 1800 мм-ээс багагүй хэмжээтэй байна.

6.7. Машины өрөөнд хоёроос доошгүй цоож бүхий нээлхий байх ёстой.

6.8. Татан чангалах төхөөрөмж нь цоож бүхий нээлхий буюу хаалгатай байх бөгөөд түүгээр эскалаторын доод тавцан руу орох боломжтой байх ёстой.

6.9. Хонгилын эскалаторын татан чангалах төхөөрөмжийн өрөө нь шаардлагатай тохиолдолд налуу эсвэл босоо хэлбэрийн орох шаттай байж болно.

Налуу шат нь 75° болон түүнээс бага өнцөгтэй бариултай байх ёстой бөгөөд шатны гишгүүрийн гүний хэмжээ нь 120 мм-ээс багагүй байна.

Босоо шат нь 75° -аас илүү өнцөгтэй бол өргөн нь 600 мм-ээс багагүй бөгөөд шатны гишгүүр хоорондын зай нь 300 мм-ээс илүүгүй байна. Босоо шатны гишгүүр нь хана болон бусад барилгын хийцээс 150 мм-ээс багагүй зайтай байх ёстой. 5-аас дээш метрийн өндөртэй шатны хувьд 3 м-ээс эхлээд хагас дугуй хэлбэрийн хайстай байх ёстой.

6.10. Хонгилын эскалаторын машины өрөө нь орох шаттай байна. Шатны эхлэл болон төгсгөлд сул талбай байх ёстой бөгөөд өргөн нь шатны өргөнтэй ижил буюу 900 мм-ээс багагүй хэмжээтэй байх ёстой. Шатны өнцөг нь 45° -аас илүүгүй байх ёстой. Шат нь бариултай байх ёстой бөгөөд гишгүүр нь хэвтээ байрлалд 200 мм-ээс илүүгүй өндөртэй байна.

6.11. Суурин өргөх байгууламж байрлуулах боломжгүй тохиолдолд эскалатор угсрах төсөлд угсралт, задаргаа хийх боломжтой өргөх төхөөрөмжийг урьдчилан тооцсон байх ёстой.

6.12. Хонгилын эскалаторын машины өрөө нь эрүүл ахуйн шаардлага хангасан агаар сэлгэлтийн системтэй байх ёстой.

6.13. Эскалаторуудын хооронд болон захын эскалатор ба хонгилын ханын хоорондын зайд 350мм-ээс багагүй өргөнтэй, 200мм-ээс илүүгүй өндөртэй гишгүүрүүд хийгдсэн байх ёстой бөгөөд налалтын өнцөг нь тогтмол байна.

6.14. Эскалаторын орох хэсэгт зорчигч ороход саад болох ямар нэгэн байгууламж хийхийг хориглоно. Харин орох хэсгийн гадна зорчигчдыг чиглүүлэх зориулалттай хайс, эскалаторын ажиллагаанд хяналт тавих ажилтны байр зэргийг хийж болно.

6.15. Эскалаторын орох хэсэгт 4.5 м-ээс доошгүй урттай сул талбай байх ёстой.

6.16. Хэд хэдэн эскалаторыг цуваагаар дараалан угсрах тохиолдолд, ижил хүчин

чадалтай эскалаторуудыг сонгох бөгөөд тус бүрд нь орох, гарах тусгайлсан талбай хийгдээгүй бол орох талбайн уртын хэмжээ нь энэхүү дүрмийн 6.15,-д заасан шаардлагыг хангах ёстой.

6.17. Эскалаторын шатны гишгүүрээс босоо чиглэлд тааз, дам нурууны доод хэсэг, тэдгээрт бэхэлсэн төрөл бүрийн гоёл, чимэглэл, гэрэлтүүлэг хүртэлх зай нь 2300 мм-ээс багагүй байх ёстой.

6.18. Давхрын эскалаторын бариулын тэнхлэг болон хучилт хүртэлх зай, эсвэл зэрэгцээ хоёр эскалаторын бариулын тэнхлэг хоорондын зай нь 500 мм-ээс бага байгаа бол хучилт эсвэл хашлагын доод ирмэг хүртэлх хэсэгт хамгаалах босоо самбар байх ёстой. Самбарын ирмэг нь гөлгөр, дугуй хэлбэртэй байх бөгөөд өндөр нь 250 мм-ээс багагүй хэмжээтэй байна.

6.19. Хонгилын эскалаторын машины болон татан чангалах төхөөрөмжийн өрөө түүнчлэн давхрын эскалаторын дээд, доод хэсэгт 42 в-оос дээшгүй хүчдэлтэй тэжээл авах зөөврийн гэрлийн залгуурууд хийгдсэн байх ёстой.

Эскалаторын хонгилд залгууруудыг 20 м-ээс илүүгүй зайд байрлуулах ёстой.

Гагнуурын аппарат, цахилгаан багаж гэх мэт зөөврийн цахилгаан тоног төхөөрөмжийг залгахад зориулж машины болон татан чангалах төхөөрөмжийн өрөөнд цахилгаан тэжээлийн залгууруудыг байрлуулна.

7. ЭСКАЛАТОРЫН ЗУРАГ ТӨСӨЛ ЗОХИОХ, ҮЙЛДВЭРЛЭХ, УГСРАХ, ШИНЭЧЛЭЛТ ХИЙХ, АШИГЛАХ, ЗАСВАР ХИЙХЭД ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ

7.1. Эскалаторын зураг төсөл зохиох, үйлдвэрлэх, угсрах, өөрчлөлт шинэчлэлт ба засвар хийх тусгай зөвшөөрлийг Барилгын асуудал эрхэлсэн Төрийн захиргааны төв байгууллагаас холбогдох хуулийн дагуу мэргэжлийн байгууллагад олгоно.

7.2. Энэ дүрмийн шаардлагыг хангасан баталгаа бүхий эд ангиудаас иж бүрдэл болгон нийлүүлдэг үйлдвэрт энэхүү зөвшөөрлийг олгож болно.

8. ЭСКАЛАТОРЫГ ҮЙЛДВЭРЛЭХ, ӨӨРЧЛӨН ШИНЭЧЛЭХ, УГСРАХ,

ЗАСВАРЛАХ БА АШИГЛАХ

8.1. Эскалаторыг үйлдвэрлэх, өөрчлөн шинэчлэх, угсрах, засварлах ба ашиглахдаа энэ чиглэлээр мэргэшсэн зураг төслийн байгууллагын гаргасан техникийн баримт, бичгийн дагуу гүйцэтгэнэ.

Эскалаторыг өөрчлөн шинэчлэх, угсрах, засварлах үед тухайн шатыг үйлдвэрлэсэн үйлдвэрийн техникийн баримт бичигт заасан ашиглалт, аюулгүй ажиллагааны зааврын дагуу өргөн тээвэрлэж, угсрах ба буулгах үйл ажиллагааг гүйцэтгэнэ.

8.2. Эскалаторыг үйлдвэрлэх, өөрчлөн шинэчлэх, угсрах, засварлах, ашиглах үүргийг энэхүү дүрмийн дагуу хүлээж байгаа байгууллага зөрчил гаргавал хариуцлага хүлээнэ.

Эскалаторын хийц эд ангиуд нэг үйлдвэрт хийгдээгүй бол түүний чанар, техникийн баримт бичгийн бүрдлийн асуудлыг бэлтгэн нийлүүлэгч, хэрэв эскалаторт их

засварын ажил хийгдсэн бол дээрх асуудлыг гүйцэтгэсэн байгууллага хариуцна.

8.3. Эскалаторыг үйлдвэрлэх явцад түүний хийцэд өөрчлөлт хийх шаардлага гарвал, өөрчлөлт нь энэхүү дүрмийн заалтуудтай нийцэж байгаа эсэх талаар зохиогч, захиалагч, барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага харилцан зөвшилцөж, шийдвэрлэнэ.

Мөн эскалаторыг өөрчлөн шинэчлэх, угсрах, засварлах явцад техникийн баримт, бичигтэй зөрчилдөх тохиолдол гарвал зохиогч, угсарч нийлүүлсэн үйлдвэр, барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай зөвшилцөж, шийдвэрлэнэ.

Техникийн паспорт дээр хийгдсэн өөрчлөлтийг тодорхой бичиж, гүйцэтгэсэн байгууллагын даргын гарын үсэг, тамгаар баталгаажуулсан байна.

8.4. Шинээр үйлдвэрлэгдсэн эскалатор бүр нь байгууллагын техник хяналтын хэлтсээр шалгагдаж, холбогдох баримт бичгийг бүрдүүлсэн байна. Үүнд:

а/ паспорт /5 дугаар хавсралтын дагуу/;

б/ угсралтын зураг;

в/ цахилгааны зарчмын схем;

г/ цахилгааны холболтын схем;

д/техникийн тайлбар бичиг;

е/ ашиглалтын заавар;

ж/ угсралт, тохиргоо, туршилт, зүгшрүүлэлтийн заавар;

з/ түргэн элэгддэг эд ангийн жагсаалт;

и/ тохиргоо ба туршилтын ажлын үед хэрэглэгдэх багажны иж бүрдэл;-

к/ эскалаторын техникийн нөхцөлд тусгагдсан эд ангийн зургийн жагсаалт;

л/ эскалатортой цуг нийлүүлэгдэх баримт бичгийн жагсаалт; Нэг барилга байгууламж дээр хоёр түүнээс дээш тоотойгоор нийлүүлэгдэх ижил төрлийн эскалаторын ашиглалт, угсралт, туршилтын үеийн болон түргэн элэгддэг эд ангийн жагсаалт бусад схем зургууд шатны тооноос цөөн байж болно. Гэхдээ 4 эскалатор бүрд нэгээс бага байж болохгүй.

Хэрэв эскалаторын хийц эд ангиуд янз бүрийн үйлдвэрт үйлдвэрлэгдсэн бол тэдгээр үйлдвэрүүдийн техникийн хяналтын хэлтсээр шалгагдсан байх ба паспортын иж бүрдүүлэлтийг нийлүүлэгч байгууллага хариуцна.

8.5. Эскалаторыг үйлдвэрлэгч нь нийлүүлэгдсэн эскалатор бүрд бүртгэл нээж түүнд

үйлдвэрийн дугаар, үйлдвэрлэсэн он сар, захиалагчийн хаяг, хүсэлт гомдлыг бичнэ. Хүсэлт гомдолд:

- Хүсэлт гаргасан байгууллагын нэр
- тухайн эскалаторын үйлдвэрийн дугаар, үйлдвэрлэсэн он сар санал хүсэлтийн товч утга

8.6. Эскалаторыг үйлдвэрлэгч нь угсралт ба ашиглалтын үед илэрсэн хийцийн согог, дутагдлыг арилгаж цаашид эскалаторыг аюулгүй ашиглах нөхцлийг бүрдүүлэх арга хэмжээг авна. Гэмтэлтэй эскалатор худалдаж авсан болон угсралт, засвар эрхэлдэг бусад мэргэжлийн байгууллагуудад илэрсэн дутагдлыг арилгах талаар аргачлал, техникийн баримт бичгийг илгээж, шаардлагатай тохиолдолд солих эд анги, зангилаануудыг нийлүүлнэ. Мөн дээрх мэдээллийг тусгай зөвшөөрөл олгогч болон улсын хяналтын байгууллагад мэдэгдэнэ.

8.7. Эскалаторт хийгдэх их засварын ажлыг барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас тусгай зөвшөөрөл авсан мэргэжлийн байгууллага нь хийж гүйцэтгэнэ.

8.8. Эскалаторыг их засварт оруулах үндэслэл нь түүний засвар хоорондын хугацааны норм эсвэл техникийн байдлаас хамаарна.

Засвар хоорондын хугацааны нормыг барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас тусгай зөвшөөрөл авсан мэргэжлийн байгууллага тогтоолгоно.

8.9. Ашиглагдаж байгаа эскалаторын хийц, үндсэн эд анги, цахилгаан хангамж, цахилгаан тоноглолын удирдлагын системд орсон өөрчлөлт нь паспортын үзүүлэлтүүдэд нөлөөлөхөөр байвал барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас авсан тусгай зөвшөөрөлтэй зураг төслийн байгууллага, эсвэл мэргэжлийн хяналтын байгууллагын дүгнэлтийг үндэс болгоно.

8.10. Эскалаторт их засвар, шинэчлэлт, өөрчлөлт хийгдсэн тохиолдолд тухайн ажлыг гүйцэтгэсэн байгууллага чанарын асуудлыг хариуцна.

8.11. Тусгай зөвшөөрөлтэй гүйцэтгэгч байгууллага эскалаторт их засвар, шинэчлэлт, өөрчлөлт хийсний дараа эзэмшигчид акт, баримт бичгээр хүлээлгэн өгнө.

8.12. Засварын ажил гүйцэтгэсэн байгууллага нь засварласан эскалатор бүрийг бүртгэлийн дэвтэрт бүртгэнэ. Үүнд:

- хүсэлт гаргасан байгууллагын нэр, хаяг
- эскалаторын үйлдвэрийн дугаар, үйлдвэрлэсэн ба засварт орсон он, сар, өдөр санал хүсэлтийн товч утга гэх мэт.

9. ЭСКАЛАТОРЫГ ТУРШИХ

9.1. Эскалаторыг шинээр үйлдвэрлэж, угсарсны дараа ашиглалтанд хүлээж авах техникийн бүрэн, ашиглалтын явцад хэсэгчилсэн болон ээлжит магадлалуудыг хийнэ.

Эскалаторын туршилтын загварыг хүлээж авах техникийн бүрэн магадлал хийхдээ улсын хяналтын байгууллагаар хянагдсан хөтөлбөр ба аргачиллын дагуу түүний төлөөлөгчийг байлцуулан хийнэ.

9.2. Шинээр үйлдвэрлэгдсэн давхрын эскалаторыг үйлдвэр дээр нь 12 цагийн туршид үндсэн хөтлөгч механизмаар ачаалалгүйгээр, чиглэл бүрд тасралтгүй 6 цаг ажиллуулан шалгаж үзнэ.

Шалгалтын явцад зөвхөн тохиргооны ажлын зориулалтаар 30 минутаас илүүгүй хугацаагаар зогсоохыг зөвшөөрнө. Үүнээс илүү хугацаагаар тохиргоо хийх, илэрсэн доголдлыг арилгах шаардлага гарвал шалгалтыг дахин явуулна.

Давхрын эскалаторыг ашиглалтанд хүлээж авахдаа дээрх байдлаар шалгаж үзнэ.

9.3. Шинээр угсрагдсан хонгилын эскалаторыг ашиглалтанд хүлээж авахдаа 48 цагийн туршид үндсэн хөтлөгч механизмаар ачаалалгүйгээр тасралтгүй ажиллуулан /чиглэл бүрд 24 цаг/ шалгаж үзнэ.

Шалгалтын явцад тохиргооны ажлын зориулалтаар 90 минутаас хэтрэхгүй хугацаагаар зогсоохыг зөвшөөрнө. Үүнээс илүү хугацаагаар тохиргоо хийх, илэрсэн доголдлыг арилгах шаардлага гарвал шалгалтыг дахин явуулна.

9.4. Их засвар, шинэчлэлт, өөрчлөлт хийгдсэн эскалаторт зүгшрүүлэлт хийхдээ техникийн баримт бичиг нормыг үндэслэн улсын хяналтын байгууллагатай зөвшилцөж явуулна.

9.5. Хэрэв шинэчлэлт, өөрчлөлт хийгдсэн эскалаторын хурд, эхэлж хөдлөх хурдатгал, тоормослох үеийн удаашралт зэрэг үзүүлэлтүүд, мөн зорчигчдын аюулгүй байдалд нөлөөлөхүйц гинж, шатны гишгүүрийн тавцан, тоормос, үндсэн механизмын цахилгаан хөдөлгүүр зэрэг эд анги, хийцүүдийн эргэх моментын инерц өөрчлөгдсөн бол шатыг ачаалалтай туршилтанд оруулна.

10. ЭСКАЛАТОРЫГ УЛСЫН БҮРТГЭЛД БҮРТГЭХ, АШИГЛАХ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ

10.1. Үндсэн асуудал

10.1.1. Шинээр угсрагдсан эскалаторыг ашиглалтанд оруулахын өмнө улсын хяналтын байгууллагын бүртгэлд бүртгүүлнэ.

Эскалаторыг улсын бүртгэлд бүртгэхдээ энэхүү дүрэмд заасан журмын дагуу явуулна.

10.1.2. Эскалаторыг дүрэмд заасны дагуу зөвшөөрөл авсан тохиолдолд ашиглана.

Эскалаторт дараах тохиолдолд ашиглах зөвшөөрлийг авна. Үүнд:

а/ шинээр угсрах. эсвэл шинэчлэлт, өөрчлөлт хийсний дараа;

б/их засвар хийгдсэний дараа;

в/техникийн магадлалын тогтоосон хугацаа дууссан;

10.1.3. Эскалаторыг зөвхөн техникийн бүрэн магадлалд оруулсны дараа ашиглана.

10.1.4. Эскалаторт угсралт, засвар техникийн үйлчилгээ хийх тусгай зөвшөөрөлтэй байгууллага эсвэл мэргэжлийн лаборатори нь техникийн бүрэн магадлал хийх бөгөөд улсын байцаагчийн зөвшөөрлөөр ашиглалтанд оруулна.

10.1.5. Эскалаторт техникийн магадлал хийх мэргэжлийн байгууллагын ажилтан нь энэхүү дүрмийн мэдлэгээр шалгалт өгч байгууллагын даргын тушаалаар томилогдсон байх ёстой.

Дүрмийн мэдлэг шалгах байгууллагын шалгалтын комисст улсын байцаагч оролцоно

Давтан шалгалтыг 3 жилд нэгээс доошгүй удаа явуулах ба шалгаптын комисст улсын хяналтын байцаагчийг заавал оролцуулах шаардлагагүй.

10.1.6. Эскалаторыг дараах тохиолдолд ашиглалтанд оруулахыг хориглоно. Үүнд:

а/ эскалаторын хийц, түүний эд ангиуд, машины ба татан чангалах төхөөрөмжийн өрөөнүүд нь энз дүрмийн шаардлага ба олон улсын стандартыг хангахгүй;

б/ эскалаторыг аюулгүй ашиглахад нөлөөлөхүйц гэмтэл илэрсэн нь үзлэг, шалгалт буюу магадлалын явцад арилгах боломжгүй болсон;

в/ улсын байцаагчийн эсвэл техникийн магадлал хийсэн ажилтны тавьсан шаардлагыг биелүүлээгүй;

г/ дүрмийн мэдлэг шалгах шалгалтад тэнцсэн бүрэн бүтэн байдал, ашиглалт, аюулгүй ажиллагааны хяналт хапиуцагч, үйлчлэх ажилчин байхгүй, эсвэл томилогдоогүй;

Зөрчил дутагдал нь аюулгүй ажиллагаанд нөлөөлөхөөргүй, үзлэг, шалгал, буюу магадлалын явцад эсвэл түүнийг ойрын хугацаанд засварын графикийн дагуу арилгах боломжтой бол эскалаторыг ашиглахыг зөвшөөрч болно.

10.1.7. Үзлэг шалгалтын үр дүнг эскалаторын паспортанд бичиж тэмдэглэнэ. Дүрмийн 10.1.6-д заагдсан зөрчил илэрвэл улсын байцаагч нь эскалаторын уйл ажиллагааг түр зогсооно.

10.1.8. Эскалаторыг эзэмшигч эсвэл түүний ашиглалтыг хариуцсан мэргэжлийн байгууллага нь илэрсэн зөрчил дутагдлыг арилгасан талаар шаардлага өгсөн байгууллагад бичгээр мэдэгдэж, цаашид ашиглах зөвшөөрлийг авна.

10.2. Шинээр суурилагдсан болон шинэчлэлт, өөрчлөлт хийгдсэн эскалаторыг ашиглах зөвшөөрөл олгох журам

10.2.1. Эскалаторыг угсарсан буюу шинэчлэлт, өөрчлөлт хийсэн байгууллага нь ерөнхий гүйцэтгэгч байгууллагатай хамтран үзлэг, шалгалт, магадлалыг хийнэ.

Эскалатор нь үзлэг, шалгалт, магадлалаар тэнцвэл угсрагч байгууллага нь техникийн бэлэн байдлын актыг 6 дугаар хавсралтын дагуу бүрдүүлж, эзэмшигч байгууллагад хүлээлгэн өгнө. Үүнд:

а/ тоног төхөөрөмж болон төмрөөр хийсэн хашлага, хаалтны газардуулгыг шалгасан баримт бичиг;

б/ удирдлага, цахилгаан төхөөрөмжийн тусгаарлагчийн эсэргүүцэл, дохиолол, хамгаалалт, гэрэлтүүлгийн цахилгааны утасны тусгаарлагчийн эсэргүүцлийг шалгасан баримт бичиг;

в/ хонгилын эскалаторын хөдөлгөөнт тавцангийн байрлуулалтанд маркшейдрийн хэмжилт хийсэн баримт бичиг;

г/ далд ажлын акт зэрэг баримт бичгүүд болно.

Барилга угсралтын байгууллага нь эскалаторын шинэчлэлт, өөрчлөлтийн ажилд оролцоогүй тохиолдолд дээрх баримт бичгийг уг ажлыг гүйцэтгэсэн байгууллага, эскалаторыг эзэмшигч байгууллагад хүлээлгэн өгнө.

10.2.2. Эскалаторыг эзэмшигч байгууллага нь энэхүү дүрмийн 10.2.1-д заагдсан баримт бичгийг бүрдүүлсний дараа ашиглалтанд хүлээж авах комиссыг дараах бүрэлдэхүүнгэй байгуулж, ажиллуулна. Үүнд:

а/ эзэмшигч байгууллагын төлөөлөгч - комиссын дарга;

б/ захиалагчийн төлөөлөгч;

в/ эскалаторыг угсарсан эсвэл шинэчлэлт, өөрчлөлт хийсэн байгууллагын төлөөлөгч;

г/ барилгын ажлын хийсэн ерөнхий гүйцэтгэгч байгууллагын төлөөлөгч;

д/ эскалаторыг үйлдвэрлэсэн байгууллагын төлөөлөгч;

е/ ашиглалтын хяналт хариуцагч;

ё/ бүрэн бүтэн байдал ба аюулгүй ажиллагааг хариуцагч;

ж/ улсын байцаагч;

10.2.3. Эскалаторыг эзэмшигч нь 5 хоногийн өмнө ацшглалтанд хүлээж авах комиссын гишүүдэд комисс ажиллах өдөр, цагийг урьдчилан мэдэгдэнэ.

10.2.4. Эскалаторыг эзэмшигч байгууллага нь ашиглалтанд хүлээн авах комисст дараах баримт, бичгийг бүрдүүлж шалгууна. Үүнд:

а/ Үйлдвэрлэгчээс ирүүлсэн эскалаторын паспорт болон дагалдах баримт, бичгүүд

б/ дүрмийн 10.2.1.-Д заасан баримт, бичгүүд;

в/ эзэмшигч байгууллагад эскалаторын ашиглалт, аюулгүй ажиллагааны дүрмийн мэдлэгээр шалгалт өгч тэнцсэн ажилтан байгааг гэрчлэх баримт, эсвэл

барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас тусгай зөвшөөрөл авсан мэргэжлийн байгууллагатай хийсэн засвар үйлчилгээ хийлгэх гэрээ;

г/ Эскалаторын ашиглалтын хяналт хариуцагч болон бүрэн бүтэн байдал ба аюулгүй ажиллагааг хариуцагчийг томилсон тушаал;

10.2.5. Эскалаторыг ашиглалтанд хүлээн авах комисс дүрмийн 11.2-т заасан үзлэг, шалгалтыг бүрэн хийнэ.

Комисс нь үзлэг, шалгалтын дүнг үндэслэн, энэхүү дүрмийн 7 дугаар хавсралтад заасан маягтын дагуу эскалаторыг ашиглалтанд хүлээн авах актыг бүрдэл болгон эзэмшигчид хүлээлгэн өгнө.

Хэрэв эскалаторыг ашиглалтанд хүлээн авахад саад болохоор зөрчил, дутагдал илэрвэл түүнийг арилгах тухай хугацаатай албан шаардлага, даалгаврыг эзэмшигчид өгнө.

10.2.6. Ашиглалтанд хүлээн авах акт ба техникийн бэлэн байдлын актыг үндэслэн, шинээр угсарсан эсвэл шинэчлэлт өөрчлөлт хийгдсэн эскалаторыг улсын бүртгэлд бүртгэн, цаашид ашиглах зөвшөөрөл олгох асуудлыг улсын байцаагч хариуцна.

Эскалаторыг улсын бүртгэлд бүртгэх, түүнийг цаашид ашиглах зөвшөөрөл нь байцаагчийн гарын үсэг ба тэмдгээр баталгаажна.

Үдэж, лацдан тэмдэг дарагдсан паспортыг эскалаторыг эзэмшигч байгууллагад хүлээлгэж өгнө.

10.2.7. Улсын бүртгэлд бүртгэх, цаашид ашиглах зөвшөөрлийг олгох ажиллагаа нь эскалаторыг ашиглалтанд хүлээн авах акт бичигдсэн өдрөөр хийгдэнэ.

10.3. Их засвар хийгдсэн эскалаторыг ашиглах зөвшөөрөл олгох журам

10.3.1. Их засвар хийгдсэн эскалаторыг цаашид ашиглах зөвшөөрлийг улсын байцаагч гаргаж өгнө.

10.3.2. Цаашид ашиглах зөвшөөрлийг дараах бүрэлдэхүүнтэй комисс ажилласны дараа олгоно. Үүнд:

а/ эзэмшигч байгууллагын төлөөлөгч- комиссын дарга;

б/ эскалаторт их засварын ажил хийсэн мэргэжлийн байгууллагын төлөөлөгч;

в/ эскалаторын ашиглалтын хяналт хариуцагч;

г/ бүрэн бүтэн байдал ба аюулгүй ажиллагааг хариуцагч;

10.3.3. Эскалаторыг эзэмшигч нь ашиглалтанд хүлээж авах комисст дараах баримт бичгийг бүрдүүлж, шалгуулна. Үүнд:

а/ паспорт;

б/ эскалаторт их засвар хийсэн тухай акт;

в/ эзэмшигч нь эскалаторын ашиглалт, аюулгүй ажиллагааны дүрмийн мэдлэгээр шалгалт өгч тэнцсэн ажилтан байгааг гэрчлэх баримт эсвэл барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас тусгай зөвшөөрөл авсан мэргэжлийн байгууллагатай хийсэн засвар үйлчилгээ хийлгэх гэрээ;

г/ эскалаторын ашиглалтын хяналт хариуцагч болон бүрэн бүтэн байдал ба аюулгүй ажиллагааг хариуцагчийг томилсон тушаал;

10.3.4. Эскалаторыг ашиглалтанд хүлээн авах комисс нь энэхүү дүрмийн 11.2-т заасан үзлэг, шалгалтыг бүрэн хийнэ.

Комисс нь үзлэг, шалгалтын дүнг үндэслэн эскалаторыг ашиглалтанд хүлээн авах актыг үйлдэж эзэмшигчид хүлээлгэн өгнө.

Хэрэв эскалаторыг ашиглалтанд хүлээн авахад саад болохоор зөрчил, дутагдал илэрвэл түүнийг арилгах тухай албан шаардлага, дүгнэлтийг эзэмшигч байгууллагад өгнө.

10.3.5. Ашиглалтанд хүлээн авах актыг үндэслэн их засвар хийгдсэн эскалаторыг цаашид ашиглах зөвшөөрлийг мэргэжлийн хяналтын байгууллага болон зөвлөх үйлчилгээ үзүүлэгч олгоно.

10.4. Техникийн магадлалын хугацаа дууссан эскалаторыг цаашид ашиглах зөвшөөрөл олгох журам

10.4.1. Техникийн магадлалын хугацаа дууссан эскалаторт цаашид ашиглах зөвшөөрлийг барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас тусгай зөвшөөрөл авсан мэргэжлийн байгууллагын төлөөлөгч, эзэмшигч байгууллагын ашиглалтын хяналт хариуцагч болон бүрэн бүтэн байдал ба аюулгүй ажиллагааг хариуцагч нарыг байлцуулан мэргэжлийн хяналтын байгууллага болон зөвлөх үйлчилгээ үзүүлэгч олгоно.

10.4.2. Эскалаторыг цаашид ашиглах зөвшөөрлийг олгохдоо энэ дүрмийн 1.3-т заасан техникийн бүрэн магадлалыг хийсэн байна.

Техникийн магадлалын үр дүн ба эскалаторыг цаашид ашиглах зөвшөөрөл, дараагийн магадлал хийх хугацааг мэргэжлийн хяналтын байгууллага, зөвлөх үйлчилгээ үзүүлэгч нь паспорт дээр бичиж баталгаажуулна.

11. ЭСКАЛАТОРТ ХИЙГДЭХ ТЕХНИКИЙН МАГАДЛАЛ.

11.1. Үндсэн асуудал

11.1.1. Шинээр угсрагдсан, шинэчлэлт өөрчлөлт хийгдсэн буюу их засварт орсон эскалаторт ашиглах зөвшөөрлийг олгохдоо техникийн бүрэн магадлалыг хийсэн байвал зохино.

11.1.2. Эскалаторыг ашиглах зөвшөөрлийг олгосны дараа техникийн ээлжит магадлалыг жилд нэгээс доошгүй удаа хийнэ.

11.1.3. Шинээр угсрагдсан, шинэчлэлт өөрчлөлт хийгдсэн эскалаторт техникийн магадлалыг энэ дүрмийн 10 дугаар бүлэгт заагдсан байгууллага ба комисс эрхлэн явуулна.

Бусад тохиолдолд техникийн магадлалыг эскалатор ашиглах зөвшөөрлийг олгох эрх бүхий ажилтан хариуцан явуулна.

11.1.4. Эскалаторт хийгдэх техникийн ээлжит магадлалыг дараах бүрэлдэхүүнтэй хийнэ. Үүнд:

- эскалаторыг эзэмшигч байгууллагын төлөөлөгч- комиссын дарга;
- ашиглалтын хяналт хариуцагч;

эскалаторын бүрэн бүтэн байдал хариуцагч мэргэжлийн байгууллага ба аюулгүй ажиллагааг хариуцагч;

11.1.5. Эскалаторыг их засварт оруулсны дараа хийгдэх техникийн магадлалд дүрмийн 11.1.4.-т заагдсан бүрэлдэхүүн дээр нэмж засварын ажил хийсэн байгууллагын төлөөлөгч болон мэргэжлийн хяналтын байгууллага болон зөвлөх үйлчилгээ үзүүлэгчийг заавал оролцуулна.

Техникийн магадлалын үр дүнг мэргэжлийн хяналтын байгууллага оолон зөвлөх үйлчилгээ үзүүлэгч эскалаторын паспорт дээр тэмдэглэл хийж, баталгаажуулна.

11.2. Техникийн бүрэн магадлал

11.1.4. Техникийн бүрэн магадлал нь дараах зорилгыг агуулна. Үүнд:

а/ эскалаторын техникийн байдал нь энэхүү дүрэм ба техникийн бусад баримт бичгийн шаардлагыг хангаж байгаа эсэх;

б/ эскалатор нь ашиглалт, аюулгүй ажиллагааны шаардлагыг хангаж байгаа эсэх;

в/ эскалаторын ашиглалтын байдал нь энэхүү дүрмийн дагуу байгаа эсэхийг шалгаж, тогтооно.

11.1.5. Эскалаторын техникийн бүрэн магадлалаар энэ дүрмийн 9 дүгээр бүлэгт заасан туршилтаас гадна дор заасан үзлэг, шалгалтыг гүйцэтгэнэ.

11.1.6. Техникийн бүрэн магадлалыг дараах журмаар хийнэ. Үүнд:

а/ эскалаторын ашиглалт нь энэ дүрмийн шаардлагыг хангаж байгаа эсэх;

б/ улсын байцаагчийн албан шаардлагын биелэлт;

в/ эскалаторын угсралт, түүнийг байрлуулсан зай хэмжээ нь энэхүү дүрэм ба “Барилгын норматив баримт бичгийн тогтолцоо. Үндсэн журам”-ын заалтыг хангаж байгаа эсэх;

г/ эскалаторын техникийн байдал, ажиллах чадвар;

д/ магадлалын үр дүнд боловсруулалт хийх зэрэг ажлуудыг гүйцэтгэнэ.

Эскалаторын ашиглалтын үеийн зохион байгуулалтын ажлыг шалгахдаа дараах зүйлийг заавал нягтлана. Үүнд:

- эскалаторын паспорт ба түүнд тэмдэглэгдсэн улсын бүртгэлийн дугаар, ашиглалт, аюулгүй ажиллагааг хариуцагчийн гарын үсэг, түүнийг томилсон тушаалын дугаар, он сар, өдөр;

- ашиглалтын баримт, бичгүүд;

- дүрмийн мэдлэгийг шалгах шалгалтыг үйлчлэх ажилчдаас цаг тухайд нь авч байсан эсэхийг шалгана.

Эскалаторыг шинээр угсарсан эсвэл шинэчилж өөрчилсөн тохиолдолд түүнийг байрлуулсан зай хэмжээ болон угсралтын ажил нь энэхүү дүрмийн заалтуудыг хангаж байгаа эсэхийг шалгана.

Эскалатор түүний ажиллагааг шалгахдаа дараах зүйлийг заавал нягтална. Үүнд:

-ажлын тоормосны тохиргоог шалгахдаа түүний баригч эд ангиудын завсар хоорондын зөвшөөрөгдөх зай хэмжээ ба гишгүүрийн тавцанг зогсоох үеийн тоормосны замын сул явалт;

-татах гинж, гишгуурийн тавцангийн даацын хийц, дугуй, чиглүүлэгч замын байдал;

-ослоос хамгаалах хоригийн төхөөрөмжийн ажиллагаа, түүний тохиргоо;

-орох талбайн тохиргоо;

-баруул, түүний төхөөрөмжийн завсар зай, хөдөлгөөнт тавцангийн хөдөлгөөний хурдтай харьцуулсан ялгаа;

-хаалт хашлаганы байдал;

-цахилгаан төхөөрөмжийн байдал;

-удирдлагын аппаратын ажиллагаа;

-хөдөлгөөнт тавцангийн хэмжээ, завсар зайг янз бүрийн байрлалд;

- эскалаторын ажиллагааг үндсэн ба засварын хурдны горимд тус тус шалгана.

11.1.7. Магадлал, туршилтын дүн хангалттай байвал эскалаторыг цаашид ашиглах зөвшөөрөл болон дараагийн магадлал хийх хугацааг магадлал хийсэн улсын байцаагч паспорт дээр бичижтэмдэглэнэ.

11.1.8. Магадлалын явцад илэрсэн зөрчил нь эскалаторын ашиглалт ба үйлчилгээнд аюултай байдал үүсгэхээр бол эскалаторын ажиллагааг зогсоож энэ тухай паспортанд тэмдэглэнэ.

11.3. Техникийн ээлжит магадлал

11.1.4. Техникийн ээлжит магадлал ба эскалаторт их засвар хийсний дараа хийгддэг магадлалуудыг дүрмийн 11.2-т заасны дагуу хийх ба харин эскалаторын угсралт, түүнийг байрлуулсан зай хэмжээг шалгах шаардлагагүй.

11.1.5. Магадлалын дүн хангалттай байвал эскалаторыг цаашид ашиглах зөвшөөрөл болон дараагийн магадлал хийх хугацааг засвар, техникийн үйлчилгээ хийх тусгай зөвшөөрөл бүхий мэргэжлийн байгууллагын хариуцлага бүхий ажилтан паспорт дээр бичнэ.

11.1.6. Магадлалын явцад энэ дүрмийн 10.1.6 дугаар заалтыг зөрчсөн зөрчил илэрвэл эскалаторын ашиглалтыг зогсоож, энэ тухай паспорт дээр тэмдэглэнэ.

12. ЭСКАЛАТОРЫН АШИГЛАЛТ

12.1. Эскалаторыг эзэмшигч нь эскалаторын бүрэн бүтэн байдал, аюулгүй ажиллагаа, засвар техникийн үйлчилгээ болон бусад арга хэмжээг цаг тухайд нь зохион байгуулах үүргийг хүлээнэ. Үүнд:

- эскалаторын ашиглалтын хяналт хариуцагч болон бүрэн бүтэн байдал ба аюулгүй ажиллагааг хариуцагчийг томилох;
- сургалтанд хамрагдаж, дүрмийн мэдлэгээр шалгалт өгч тэнцсэн ажилчдыг эскалаторыг ажиллуулах болон засвар, техникийн үйлчилгээ хийх ажилд тушаалаар томилох;
- эскалаторын үзлэг шалгалт, засвар техникийн үйлчилгээний ажлыг зохион байгуулах, хэрэв мэргэжлийн бус байгууллага бол тусгай зөвшөөрөл бүхий мэргэжлийн байгууллагатай засвар, техникийн үйлчилгээний гэрээ хийж, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулсан байх;
- эскалаторт үйлчлэх ажилчдаас дүрмийн мэдлэгээр шалгалт авах, сургалт явуулах ажлыг зохион байгуулсан байх;
- эскалаторын ашиглалтын хяналт хариуцагч, бүрэн бүтэн байдал ба аюулгүй ажиллагааг хариуцагч, үйлчлэх ажилчдыг аюулгүй ажиллагааны дүрэм, ажлын байрны тодорхойлолт, холбогдох баримт бичгээр хангах;
- эскалаторын удирдлага, машины өрөөний түлхүүрийг хадгалах ба хүлээлцэх журмыг тогтоосон байна.

12.2. Эскалаторын ашиглалтын хяналт хариуцагч, бүрэн бүтэн байдал ба аюулгүй ажиллагааг хариуцагчид нь энэ дүрмийн 8 ба 9 дүгээр хавсралтад заасан үүргийг хүлээнэ.

12.3. Бүрэн бүтэн байдал ба аюулгүй ажиллагааг хариуцагчийн албан тушаал, овог нэр, гарын үсэг мөн түүнийг томилсон тушаалын дугаар, он сар өдөр зэрэг нь эскалаторын паспорт дээр бичигдсэн байна.

Эскалаторын ашиглалтын хяналт хариуцагч болон бүрэн бүтэн байдал ба аюулгүй ажиллагааг хариуцагч нь ээлжийн амралт, томилолтоор явсан, өвчтэй зэрэг түр эзгүй

тохиолдолд дүрмийн мэдлэгийн шалгалтыг, хяналтын газрын шаардлагын дагуу өгч тэнцсэн албан хаагчдыг тушаалаар томилно. Паспорт дээр энэ тухай бичих шаардлагагүй.

12.4. Эскалаторыг ашиглах, засварлахдаа эзэмшигч байгууллага нь тусгай зөвшөөрөл бүхий мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлж болно.

Байгууллага хоорондын гэрээний эрх, үүрэгт энэ дүрмийн 12.1 дүгээр заалтыг заавал тусгасан байна.

12.5. Засвар, үйлчилгээ хийх ажилтнууд нь сургалтанд хамрагдаж үйлдвэрлэлийн болон эскалаторыг ашиглах заавар болон энэхүү дүрмийн мэдлэгээр шалгалт өгч тэнцсэн байх ёстой.

12.6. Эскалаторыг түүний оператор ажиллуулах ёстой.

Оператор нь хөтөлбөрийн дагуу суралцаж, эскалаторын ажиллагаа, аюулгүй ашиглах дүрмийн мэдлэгийн шалгалтыг өгч, тэнцсэн байна.

Автомат буюу телемеханикаар дохио өгөх системээр төхөөрөмжлөгдсөн эскалаторыг диспетчер удирдаж болно.

12.7. Хонгилын эскалаторын доод хэсгийн орох талбайгаас хөдөлгөөнт тавцан дээрх зорчигчдыг байнгын хянах боломжийг хангасан байх ёстой.

Жижүүрийн оператор нь зорчигчдод гэмтэл учруулж болзошгүй аюултай байдал үүсвэл эскалаторыг зогсооно.

12.8. Эскалаторын оператор, засварчин зэрэг үйлчлэх ажилчид нь 18 нас хүрсэн, эрүүл мэндийн үзлэгээр орж тэнцсэн, эрх бүхий байгууллагаас зөвшөөрөлтэй сургалтын төвд зохих хөтөлбөрийн дагуу суралцаж, дүрмийн мэдлэгийн шалгалтыг өгч тэнцсэн хүмүүс байна.

Сургалт явуулсан байгууллагын мэргэжлийн комисс нь эскалаторын ажиллагааны болон дүрмийн мэдлэгийн шалгалтыг авна.

Шалгалтын комисст мэргэжлийн хяналтын байгууллагын төлөөлөл заавал оролцоно. Шалгалт авах хугацааг 5 хоногийн өмнө хяналтын байгууллагад мэдэгдэнэ. Шалгалтанд тэнцсэн хүмүүст комиссын дарга, хяналтын байгууллагын ажилтан нарын гарын үсэг зурсан мэргэжлийн үнэмлэх олгоно. Үнэмлэх нь фото зурагтай байх ба тамга дарагдаж, баталгаажсан байна.

12.9. Дүрмийн мэдлэгийг шалгах давтан ба ээлжит бус шалгалтыг байгууллагын тушаалаар томилогдсон мэргэжлийн комисс дараах тохиолдолд авна. Үүнд:

- ээлжит шалгалтыг жилд нэгээс доошгүй удаа;
- нэг байгууллагаас нөгөө байгууллагад эсвэл нэг төрлийн эскалатораас өөр төрлийн эскалаторт шилжин ажиллах тохиолдолд;
- хяналт хариуцагч ажилтан эсвэл мэргэжлийн хяналтын байгууллагын ажилтны

шаардлагаар;

- үүрэгт ажлаа 6 -аас дээш сарын хугацаагаар хийгээгүй завсарласан;

Аюулгүй ажиллагааны зааварчилга, үйлдвэрлэлийн дүрэм, журам, заавар зөрчсөн ажилтнаас ээлжит бус дүрмийн мэдлэгийн шалгалтыг авна.

Дүрмийн мэдлэгийг шалгах шалгалтанд хангалтгүй дүн авсан ажилчдаас дахин авах давтан шалгалтын хугацааг мэргэжлийн комисс тогтооно.

Шалгалтын комисст мэргэжлийн хяналтын ажилтан оролцох шаардлагагүй.

12.10. Мэргэжлийн комиссын гишүүд нь дүрмийн мэдлэгийн шалгалтыг хяналтын байгууллагад шалгуулан тэнцсэн байна.

Мэргэжлийн комиссын гишүүдээс авах дүрмийн мэдлэгийг шалгах болон давтан шалгалтыг 3 жилд нэгээс доошгүй удаа мэргэжлийн хяналтын байгууллага авна.

12.11. Дүрмийн мэдлэгийг шалгах давтан ба ээлжит бус шалгалтын явцын тэмдэглэлийг хөтлөн дүнг мэргэжлийн үнэмлэх дээр тэмдэглэнэ.

12.12. Ашиглалт, засвар, угсралтын ажлыг удирдах мэргэжилтнүүд нь албан тушаалдаа томилогдохоос өмнө энэхүү дүрмийн болон бусад холбогдох нормативт мэдлэгийн шалгалтыг өгч тэнцсэн байх ёстой.

12.13. Зураг төсөл зохиогч, үйлдвэрлэгч, бэлтгэн нийлүүлэгч, засвар, угсралт, эзэмшигч байгууллагуудын удирдах ажилтан, мэргэжилтнүүд нь энэхүү дүрмийн мэдлэгийг шалгах давтан шалгалтыг 3 жил тутамд мэргэжлийн хяналтын байгууллагад өгнө.

12.14. Дараах ажилтнууд нь “Цахилгаан байгууламжийн ашиглалтын үед мөрдөх аюулгүй ажиллагааны дүрэм”-ээр тогтоогдсон ажиллагаатай байгаа цахилгаан байгууламжид ажил гүйцэтгэх аюулгүй ажиллагааны мэргэжлийн группийн ангиллыг авсан байна. Үүнд:

- IY групп- эскалаторын ашиглалтын хяналт ба бүрэн бүтэн байдал хариуцагчид;
- III групп- эскалаторыг удирдаж ажиллуулах оператор болон засвар техникийн үйлчилгээний ажилчид хамрагдана.

12.15. Эскалаторын оператор, бүрэн бүтэн байдал ба аюулгүй ажиллагааг хариуцагч нь гэмтсэн хүнд эмнэлгийн анхан шатны тусламжийг үзүүлж чадах чадвар бүхий байх ёстой.

12.16. Эскалаторын засвар техникийн үйлчилгээний ажилчид, оператор, хөдөлгөөнт тавцан дээрх зорчигчдод зайнаас хяналт тавих ажилчид нь сургалтанд хамрагдаж мэргэжлийн үнэмлэх авсан, үйлдвэрлэлийн ажлын байрны тодорхойлолт, аюулгүй ажиллагааны зааварчилгатай танилцаж, тушаалаар томилогдсон байна.

12.17. Эскалаторыг ажиллуулж эхлэхийн өмнө хоногт нэгээс цөөнгүй удаа техникийн үзлэг, шалгалт, тохиргоог хийнэ.

Давхрын эскалаторын үзлэгийн үечлэлийн хугацааг мэргэжлийн хяналтын байгууллагатай зөвшилцөн өөрчилж болно.

12.18. Эскалаторын оператор нь үзлэгийг үйлдвэрлэлийн болон ашиглалтын зааврын дагуу гүйцэтгэх ёстой.

Эскалаторын техникийн үзлэгийг бүрэн бүтэн байдал, аюулгүй ажиллагааг хариуцагч шаардлагатай тохиолдолд гүйцэтгэж болно.

Үзлэгийн үр дүн болон илэрсэн зөрчлийг арилгасан тухай тэмдэглэлийг техникийн үзлэг, үйлчилгээний дэвтэрт бичнэ.

12.19. Эскалаторын засвар, техникийн үйлчилгээний ажлыг үйлдвэрлэсэн байгууллагын техникийн баримт бичиг, ашиглалтын зааврын дагуу тусгай зөвшөөрөл бүхий мэргэжлийн байгууллага гүйцэтгэнэ.

Засвар, техникийн үйлчилгээний үр дүн, илэрсэн гэмтлийг арилгасан тухай тэмдэглэлийг эскалаторын техникийн үзлэг, үйлчилгээний дэвтэрт бичнэ.

12.20. Засвар, техникийн үйлчилгээний ажил эрхэлдэг эскалатор эзэмшигч, эсвэл мэргэжлийн байгууллага нь техникийн үйлчилгээний ажил болон операторт зориулан, үйлдвэрийн баримт бичигт заасныг үндэслэл болгон ажлын байрны тодорхойлолт, зааврыг боловсруулж, батлан мөрдүүлнэ.

12.21. Эскалаторын засвар техникийн үйлчилгээ, магадлалыг хийхдээ техникийн аюулгүй байдал, эрүүл ахуй, хөдөлмөрийн хамгааллын зааварчилгааны шаардлагуудыг дагаж, мөрдөнө.

12.22. Эскалаторыг ажиллаж байхад гэмтэл, согог илрэх, ашиглалтын явцад аюултай байдал бий болох зэрэг зөрчил илэрвэл түүний ажиллагааг зогсоож, зорчигчдыг буулгана.

13. ОСОЛ, АВААРИЙГ ШАЛГАН СУДЛАХ

13.1. Эскалаторыг угсрах, шинэчилж өөрчлөх, ашиглах, засварлах явцад гарсан осол, аваарийг судалж, шалгахдаа Монгол Улсын засгийн газрын 2000 оны 107 дугаар тогтоолоор батлагдсан “Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнийг судлах дүрэм”-ийн дагуу гүйцэтгэнэ.

13.2. Эскалатортай холбоотой осол, аваар гарвал эзэмшигч байгууллага нь мэргэжлийн хяналтын байгууллагад 24 цагийн дотор яаралтай мэдэгдэж, хүмүүсийн амь нас ба эрүүл мэндэд аюул учруулахааргүй бол хяналтын ажилтныг иртэл ослын ул мөрийг хэвээр байлгах үүргийг хүлээнэ.

Мөн ослын тухай мэдээллийг холбогдох байгууллагуудад мөрдөгдөж буй хууль, тогтоомжийн дагуу мэдэгдэнэ.

13.3. Эзэмшигч байгууллага нь үйлчлэх ажилчид болон зорчигчтой холбоотой гэмтэл, осол аваар, түүнчлэн эскалаторын үзлэгийн явцад илэрсэн эвдрэл, гэмтлийн талаарх жагсаалтыг хөтөлж, судалгааг гаргана.

13.4. Эзэмшигч байгууллага нь зорчигчтой холбоотой бүх төрлийн осол, аварийн талаар тусгай тэмдэглэл хөтөлнө. Шаардлагатай тохиолдолд эскалаторын техникийн бүрэн байдлыг тодорхойлох тоормосны зам, завсар зай, эд ангиудын байдал гэх зэрэгт хэмжилт хийж, ослын акт үйлдэнэ.

14. ДҮРЭМ ЗӨРЧИГЧДӨД ХҮЛЭЭЛГЭХ ХАРИУЦЛАГА

14.1. Эскалаторын зурагтөсөл, түүнийг үйлдвэрлэх, угсрах, шинэчилжөөрчлөх, засварлах, тохируулга хийх мөн барилгын хийцийн төсөл, цахилгаан хангамж, бусад тоног төхөөрөмжүүдийн чанар нь энэ дүрэмтэй нийцэж байгаа эсэхийг дээрх ажлуудыг гүйцэтгэсэн тухайн байгууллагууд хариуцна.

14.2. Эскалаторыг ашиглах ба угсрах үед түүний хийц, үйлдвэрлэлт, угсралт болон засварын ажилтай холбоотой гологдол илэрвэл эзэмшигч нь гомдлоо хариуцах тухайн байгууллагуудад гаргах бөгөөд нэг хувийг мэргэжлийн хяналтын байгууллагад хүргүүлнэ.

14.3. Гомдол хүлээж авсан байгууллага өөрт холбоотой асуудлыг судалж, гомдол нь үндэслэлтэй бол арилгах үүрэгтэй.

Илэрсэн гэмтэл, согог нь эскалаторыг цаашид ашиглахад аюултай байдал үүсгэхээр байвал гомдол хүлээн авсан байгууллага нь ийм төрлийн эскалаторыг нийлүүлсэн бусад эзэмшигч байгууллагуудад урьдчилан мэдэгдэж, гэмтлийг арилгах талаар аргачлал, техникийн зөвлөмж, баримт бичиг, солих шаардлагатай эд ангиар хангах үүргийг хүлээнэ.

Гомдлыг хүлээж авсан байгууллагууд нь ирсэн санал, гомдлыг бүртгэх дэвтрийг хөтлөнө. Дэвтэрт дараах мэдээллийг тусгана. Үүнд:

- гомдол гаргасан байгууллагын нэр;
- эскалаторын үйлдвэрийн дугаар ба гомдлын товч утга;
- гомдлын дагуу авсан арга хэмжээ зэргийг тодорхой бичнэ.

14.4. Эскалатор болон барилгын зураг төсөл зохиогч, үйлдвэрлэгч, ерөнхий гүйцэтгэгч, засвар, угсралтын болон эзэмшигч байгууллага, удирдах ажилтан, ажилчид нь энэ дүрмийг зөрчсөн бол осол, аваарь гарсан эсэхийг үл харгалзан, Барилгын тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээнэ.

14.5. Байгууллагын удирдлагын зүгээс улсын байцаагчийн гаргасан шийдвэрийг зөрчих, илэрсэн зөрчлийг газар дээр нь арилгуулах арга хэмжээ авахгүй байх, дүрэм журам, хууль тогтоомжийн заалт зөрчсөн үүрэг даалгавар өгөх зэрэг нь энэ дүрмийн ноцтой зөрчилд тооцогдоно.

14.6. Дүрэм ба зааврын зөрчил гаргах, эсвэл өөрийн санаатай үйл ажиллагаагаар эскалаторыг эвдсэн буруутай этгээд нь Барилгын тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээнэ.

1 дүгээр хавсралт

Нэр томъёо ба түүний тодорхойлолт

Нэр томъёо	Тодорхойлолт
Үндсэн нэр томъёо ба түүний тодорхойлолт	
1. Эскалатор	Зорчигчдыг нэг түвшнээс нөгөө түвшинд зөөвөрлөх
2. Зорчигч зөөврийн конвейер	Зорчигчдыг нэг түвшинд эсвэл нэг түвшнээс өөр түвшинд зөөвөрлөх зориулалттай ялтсан эсвэл цул туузан дамжуулгаас бүрдсэн тасралтгүй урсдаг зам бүхий өргөн тээвэрлэх байгууламж.
3. Эскалаторын налуу хэсэг	Эскалаторын хөдөлгөөнт тавцангийн налуу хэсэг,
4. Эскалаторын хэвтээ хэсэг	Эскалаторын хөдөлгөөнт тавцангийн хэвтээ хэсэг,
5. Эскалаторын босоо хэсэг	Налуу, хэтээ хэсгийн шугамын огтлолцлоор үүсэх босоо гадаргуу
6. Цогцолбор эскалаторын	Ерөнхий машины өрөөтэй, нэг налууд байрлагдсан эскалаторууд
7. Геометрийн залгаас бүс	Эскалаторын заагдах хоёр бүсийн загаас хэсгийг тодорхойлогч гадаргуу
8. Эскалаторын цахилгааны хориг	Эскалаторын дамжуулгын үйл ажиллагааг шаардлагатай үед хориглох төхөөрөмж
Үндсэн үзүүлэлт ба хэмжээсүүд	
9. Эскалаторын налуугийн өнцөг	Эскалаторын налуу ба хэвтээ хэсгүүдийн хоорондын өнцөг
10. Зорчигчдыг эскалатораар зөөвөрлөх өндөр	Босоо тэнхлэгийн дагуу дээд ба доод орох талбайн түвшин хоорондын зай
11. Эскалаторын хүчин чадал	Эскалатороор нэгж хугацаанд тээвэрлэгдэх зорчигчдын тоо
12. Эскалаторын ердийн хурд	Эскалаторын хэвийн горимд ачаалалгүй үеийн хөдлөх хурд
13. Эскалаторын ашиглалтын хурд	Эскалаторын хэвийн горимд үндсэн дамжуулгаар ашиглалтын үеийн хамгийн их ачаалалтай ажиллах үеийн хурд
14. Эскалаторын засварын хурд	Эскалаторын техникийн үйлчилгээ, тохируулга, засварын үед ажиллуулах хурд
15. Эскалаторын ашиглалтын хамгийн их ачаалал	Эскалаторын хөдөлгөөнт тавцангийн 1м уртад ноогдох зорчигчдын жингээс үзүүлэх хамгийн их ачаалал
16. Эскалаторын хөдөлгөөнт тавцангийн сул явалт	Үндсэн дамжуулгын цахилгаан хөдөлгүүрийг унтраасны дараа ажлын тоормос ажиллаагүй үед, хөдөлгөөнт тавцан ачаалалгүй инерцээрээ явах зай
17. Эскалаторын хөдөлгөөнт тавцангийн өргөн	Гишгүүрийн тавцангийн хажуугийн гадна ирмэгүүдийн хоорондын зай
18. Эскалаторын хөдөлгөөнт гишгүүрийн өндөр	Эскалаторын налуу хэсэг дэх дараалсан хоёр гишгүүрийн тавцангуудын хоорондын зай
19. Эскалаторын хөдөлгөөнт тавцангийн гүн	Гишгүүрийн тавцангийн урд ба хойд ирмэг хоорогндын зай

Эскалаторын төрлүүд /хэрэглэх зориулалтаар нь/	
20. Давхрын эскалатор	Барилга байгууламжийн давхар хооронд зорчигч зөөвөрлөх зориулалттай эскалатор
21. Хонгилын эскалатор	Хонгилд хүн зөвөөрлөхөөр зориулалттай эскалатор
Эскалаторын төрлүүд /дамжуулгаар/	
22. Нэг дамжуулгатай эскалатор	Ажлын механизмууд нь дамжуулгын нэг голоос хөтлөгддөг эскалатор
23. Модулийн эскалатор	Ажлын механизм нь тусдаа дамжуулгатай ижил эргэлттэй голуудаас эргэлтээ авдаг, хэд хэдэн тогтмол хийцийн элементээс бүрдсэн эскалатор
24. Нэг хурдтай эскалатор	
25. Олон хурдтай эскалатор	Ашиглалтын нэг хурд бүхий эскалатор
Эскалаторын төрлүүд /чиглүүлэгч замын байрлалаар/	
26. Налуу байрлалтай эскалатор	Чиглүүлэгч замын дунд хэсэг нь хэвтэй тэнхлэгтэй шулуун шугамаар өнцөг үүсгэн байрласан эскалатор
Эскалаторын төрлүүд /дамжуулгын хэсгийн уртаар/	
27. Уртасгасан эскалатор	Өөрийн бүрэлдэхүүн хэсэгтээ нэмэлт “Д” бүс бүхий, эскалатор /10 дугаар хавсралт/
Эскалаторын бүсүүд /10 дугаар хавсралт/	
28. Эскалаторын бүсүүд	Эскалаторын угсралтын явцад залгагддаг бүрэлдэхүүн хэсгүүд
29. “А” бүс	Эскалаторын чиглүүлэх ба татах төхөөрөмжийн муруй хэсгийг багтаасан бүс
30. “Бн” бүс	Эскалаторын “А” бүсээс дээш байрлах, шулуун шугамын ба эсрэг чиглүүлэгчийг багтаасан бүс
31. “Б” бүс	Эскалаторын “Бн” бүсээс дээш байрлах, шулуун шугамын чиглүүлэгчийг багтаасан бүс
32. “И” бүс	Эскалаторын “Б” бүсийн дараа байрлах, тодорхой урттай шулуун шугамын чиглүүлэгчийг багтаасан бүс
33. “В” бүс	Эскалаторын “И” бүсийн дараа байрлах, чиглүүлэгчийн ба бариулын дамжуулгын дээд муруй хэсгийг багтаасан дээд бүс
34. “Д” бүс	Эскалаторын “В” бүсийн дараа байрлах нэмэлт бүс
35. “Е” бүс	Эскалаторын “В” бүсийн дараа байрлах дамжуулгын механизмын бүс
36. “Ед” бүс	Уртасгасан эскалаторын “Д” бүсийн дараа байрлах дамжуулгын механизмын бүс
37. “М” бүс	Давхрын эскалаторын дамжуулгын механизм байрлах бүс
Дамжуулга	
38. Эскалаторын үндсэн гол	Эскалаторын гишгүүрийн тавцангуудыг татах одон араг хөдөлгөөнд оруулдаг гол
39. Эскалаторын үндсэн дамжуулга	Зорчигчдыг зөөвөрлөх зориулалтаар эскалаторыг хөдөлгөөнд оруулах дамжуулга
Тоормос	
40. Эскалаторын ажлын тоормос	Цахилгаан хөдөлгүүрийг унтраахад эскалаторыг зогсоох зориулалттай төхөөрөмж
Хөдөлгөөнт тавцан	
41. Эскалаторын хөдөлгөөнт тавцан	Эскалаторын татах гинжтэй холбогдсон гишгүүрүүдээс бүрдсэн, зорчигч зөөвөрлөх элемент

<p>42. Эскалаторын гишгүүр</p> <p>43. Эскалаторын гишгүүрийн үндсэн чиглүүлэгч дугуй /дээд/ 44. Эскалаторын гишгүүрийн туслах дугуй /доод/ 45. Эскалаторын гишгүүрийн гадаргуу</p> <p>46. Эскалаторын гишгүүрийн тавцангийн шүдэт ирмэг 47. Эскалаторын гишгүүрийн урднүүр 48. Эскалаторын гишгүүрийн хавчуулга, жийрэг 49. Эскалаторын хөдөлгөөнт тавцан ба бариулын чиглүүлэгч замууд</p> <p>50. Хөдөлгөөнт тавцангийн гишгүүрийн өндөр 51. Эскалаторын хөдөлгөөнт тавцангийн онгорхой зай 52. Эскалаторын хөдөлгөөнт тавцангийн хэвтээ хэсэг</p>	<p>Зорчигч зогсоход зориулагдсан хөдөлгөөнт тавцангийн хэсэг Зорчигч ба хөдөлгөөнт тавцангуудын ачааллыг авдаг, чиглүүлэгч дээгүүр гүйх гишгүүрийн өнхрөх тулгуур Зорчигч ба гишгүүрийн ачааллыг авдаг, чиглүүлэгч дээгүүр гүйх гишгүүрийн өнхрөх тулгуур Зорчигчдын аюулгүй байдлыг хангах зориулалт бүхий хөдөлгөөнт тавцангийн төвгөр ба хотгор хэлбэртэй ажлын гадаргуу Гишгүүр дээр байрлах тавцангийн дэвсгэрийн эд анги</p> <p>Гишгүүрийн нүүрний хэсэг. / гадны жижиг биет хөдөлгөөнт хэсэг лүү унахаас хамгаалах зориулалттай / Гишгүүрийн тавцанг орох талбайн шүдэт ирмэгтэй харьцуулж тохируулах зориулалттай гишгүүрийн эд анги Хөдөлгөөнт тавцан, бариулын тодорхой замаар шилжих хөдөлгөөнийг хангах зориулалттай, чиглүүлэгч, эсрэг-чиглүүлэгч, үндсэн ба туслах гүйгч дугуйн цогц бүрэлдэхүүн Дараалсан хоёр гишгүүрийн хэтээ гадаргуугийн түвшингийн зөрөө Хөдөлгөөнт тавцангийн гишгүүрийг авахад үүсэх хоосон орон зай Зорчигчдын орох ба гарах үеийн аюулгүй байдлыг хангах зориулалттай, шатны хөдөлгөөнт тавцангийн гишгүүрийн хэвтээ талбайн хэсэг</p>
Орох талбай	
<p>53. Эскалаторын орох талбайн хэсэг 54. Эскалаторын орох талбайн хөдөлгөөнгүй хэсэг 55. Эскалаторын орох талбайн шүдэт ирмэг 56. Орох талбайн шугам</p>	<p>Гишгүүрийн тавцан руу аажмаар шилжих боломж бүхий орох талбайн хэсэг Орох, гарах талбай Эскалаторын гишгүүрийн тавцангаас зорчигчдын орох, гарах үеийн аюулгүй байдлыг хангах зориулалттай, орох талбайн эд анги Шатны гишгүүрийн гадаргуу ба шүдэт ирмэгийг тохируулах зориулалттай, орохталбайн эд анги</p>
Гишгүүрийн чиглүүлэгч дугуй ба бариулын чиглүүлэгч зам	
<p>57. Эскалаторын гишгүүр ба бариулын чиглүүлэгч 58. Үндсэн чиглүүлэгч 59. Муруйлгах чиглүүлэгч 60. Гишгүүр ба бариулын чиглүүлэгчийн ажлын хэсэг 61. Эскалаторын хөдөлгөөнт тавцангийн ажлын хэсэг 62. Гишгүүр, бариулын</p>	<p>Ажлын ба ажлын бус салбар хэсгээс бүтсэн хөдөлгөөнт тавцан болон бариулын замын чиглүүлэгч элементүүд Гишгүүрийн ажлын хэсэг дэх үндсэн гүйгчийн чиглүүлэгч зам Ажлын ба ажлын бус салбар хэсэг дунд байрлах туслах гүйгчийн чиглүүлэгчийн шилжилтийн муруйлттай хэсэг Зорчигчийн бүсэд байрласан чиглүүлэгч Зорчигчийн бүсэд байрлах хөдөлгөөнт тавцангийн хэсэг Хөдөлгөөнт тавцангийн гишгүүр, бариулыг эргүүлэх</p>

<p>чиглүүлэгчийн ажлын бус хэсэг 63. Гишгүүрийн эсрэг чиглүүлэгч</p> <p>64. Гишгүүрийн чиглүүлэгчийн хажуу гадаргуу 65. Гишгүүрийн чиглүүлэх оролт</p>	<p>зориулалттай чиглүүлэгч Гишгүүрийн тавцан унах, тохиолдлоор өргөгдөх мөн татах гинж тасарсан тохиолдолд түүнийг давхралдаж, овоорохоос хамгаалчх зориулалттай шатны гишгүүрийн тавцангуудын замын элемент</p> <p>Хөдөлгөөний үед гишгүүрүүдийн хөндлөн шилжилтийг хязгаарлах зориулалттай чиглүүлэх хэсэг Гишгүүрийн чиглүүлэгч лүү үндсэн гүйгч алгуур, зөв орох нөхцлийг хангасан хэсэг</p>
<p>Хашлага</p>	
<p>66. Эскалаторын хашлага</p> <p>67. Дунд хашлага</p> <p>68. Захын хашлага</p> <p>69. Гадна хашлага</p> <p>70. Хажуугийн хашлага</p> <p>71. Хашлаганы карниз</p> <p>72. Хашлаганы плинтус</p> <p>73. Хашлаганы хормой</p> <p>74. Хашлаганы штапик</p>	<p>Зорчигчдыг эскалаторын механизм, металл хийцээс хамгаалж, аюулгүй байдлыг хангах зорилгоор хийгдсэн босоо хаалт, хөвөө болон бусад хэсгээс бүрдсэн иж бүрдэл Зэргэлдээ хоёр эскалаторын карнизны дунд байрлах хашлаганы хэсэг Захын эскалаторын хөвөө болон барилгын хийцийн хооронд байрлах хашлаганы хэсэг Зорчигчдын орох, гарах хэсэгт байрладаг, орох тавцан ба захын хашлаганд тулж бэхлэгдсэн хашлаганы хэсэг. Хөдөлгөөнт тавцангийн хоёр талд хормой ба хүрээний хооронд эсвэл завсар байрлах хашлаганы хэсэг. Бариулын чиглүүлэгч зам ба босоо хаалтуудыг бэхэлдэг хашлагын элемент Босоо самбаруудыг бэхэлдэг, хормой дээр байрлах хашлаганы элемент Хөдөлгөөнт тавцангийн чиглэлийн дагуу гишгүүртэй нэг түвшинд байрлах, гишгүүр ба хашлаганы хоорондын зайг тохируулах үүрэгтэй, хашлаганы доод босоо хэсэг Зэргэлдээ байрлах босоо хаалтуудын завсар зайг хаадаг хашлаганы элемент</p>
<p>Бариулын төхөөрөмж</p>	
<p>75. Эскалаторын бариулын төхөөрөмж</p> <p>76. Эскалаторын бариул</p> <p>77. Бариулын амсар</p> <p>78. Бариулын ирмэг 79. Бариулын бүрээс</p>	<p>Замын дагуу бариулын шилжих хөдөлгөөнийг хангадаг, чиглүүлэгч, дамжуулга ба өнхрөх тулгууруудаас бүрдэх хийцийн нэгдэл. Зорчигчдын гарт тулгуурын үүрэг гүйцэтгэдэг, бариулын төхөөрөмжийн чиглүүлэгч замаар урсан шилждэг битүү тууз Бариул нь ажлын ил хэсгээс ажлын бус далд хэсэгт шилжих цэгт байрлах төхөөрөмж Шилжих хөдөлгөөнийг чиглүүлж, тогтоох үүрэгтэй, Бариулын гадна талын өнгөлгө, ө гоёлын хэсэг</p>
<p>Цахилгааны хориг</p>	
<p>80. Эскалаторын бариулын татагчийн хориг</p>	<p>Бариул хэт чангалах буюу тасрах үед цахилгаан хөдөлгүүрийг салгах хориг</p>

<p>81. Эскалаторын бариулыг зогсоох хориг</p> <p>82. Эскалаторын татан чангалах төхөөрөмжийн хориг</p> <p>83. Эскалаторын ажлын тоормосны хориг</p> <p>84. Эскалаторын орох талбайн хориг</p> <p>85. Эскалаторын бариулын төхөөрөмжийн амсрын хориг</p> <p>86. “ЗОГС” хориг</p> <p>87. “ЗОГС” салгуур</p> <p>88. Эскалаторын гишгүүрийн өргөлтийн хориг</p> <p>89. Эскалаторын гишгүүрийн буулгалтын хориг</p> <p>90. Эскалаторын гишгүүрийн чиглүүлэгч дугуйн хориг</p> <p>91. Эскалаторын бариулын хориг</p> <p>92. Эскалаторын гишгүүрийн тэнхлэгийн хориг</p> <p>93. Эскалаторын цахилгаан хангамжийгунтраах хориг</p> <p>94. Эскалатор дээр зорчигч унах үед ажиллах хориг</p> <p>95. Дамжуулгын гинжний хориг</p> <p>96. Эскалаторын гишгүүрийг авсны дараа ажиллах төхөөрөмжийн хориг</p> <p>97. Эскалаторын татах гинжний автомат тосолгооны төхөөрөмжийн хориг</p>	<p>Бариулыг зогсох буюу хурд нь багассан үед ажиллаж цахилгаан хөдөлгүүрийг зогсоох хориг</p> <p>Татан чангалах төхөөрөмжийн одон арааны байрлал зөвшөөрөгдөх хэмжээнээс ихэссэн үед цахилгаан хөдөлгүүрийг зогсоох хориг</p> <p>Цахилгаан хөдөлгүүрийн тоормосны колодка давхэрдах буюу цахилгаан соронзон якорь зөвшөөрөгдөх хэмжээнээс хоцорч хөдлөх үед цахилгаан хөдөлгүүрийг зогсоох хориг</p> <p>Орох талбай хөндлөн тэнхлэгийн дагуу шилжих буюу өргөгдөх үед цахилгаан хөдөлгүүрийг зогсоох хориг</p> <p>Бариулын төхөөрөмжийн амсарт гадны биет орсон тохиолдолд цахилгаан хөдөлгүүрийг зогсоох хориг</p> <p>Эскалаторт үйлчлэх ажилтан цахилгаан хөдөлгүүрийг дурын газар эсвэл хашлаганы гаднаас зогсоох хориг</p> <p>Зорчигч болон үйлчлэх ажилтан цахилгаан хөдөлгүүрийг зогсоох салгуур</p> <p>Орох тавцангийн өмнө гишгүүр өргөгдөх үед цахилгаан хөдөлгүүрийг унтраах хориг</p> <p>Гишгүүр буух үед цахилгаан хөдөлгүүрийг унтраах хориг</p> <p>Гишгүүрийн өнхрөх тулгуурт гэмтэл гарсан үед цахилгаан хөдөлгүүрийг унтраах хориг</p> <p>Замын доод муруй хэсэг бариул чиглүүлэгчээс мултарсан үед цахилгаан хөдөлгүүрийг унтраах хориг</p> <p>Гишгүүрийн тэнхлэг мултарсан үед цахилгаан хөдөлгүүрийг унтраах хориг</p> <p>Ажилтны буруу үйлдлээр цахилгаан хүчний хангамжийг залгах үед цахилгаан хөдөлгүүрийг унтраах хориг</p> <p>Дээд, доод тавцангийн ойролцоо зорчигч унах үед цахилгаан хөдөлгүүрийг унтраах хориг</p> <p>Дамжуулгын гинж тасрах эсвэл хэт чангарсан үед цахилгаан хөдөлгүүрийг унтраах хориг</p> <p>Төхөөрөмжийн арал нээгдсэн үед цахилгаан хөдөлгүүрийг унтраах хориг</p> <p>Татах гинжний автомат тосолгооны төхөөрөмжтэй үед эскалаторыг буруу ажиллуулахаас хамгаалсан хориг</p>
<p>Өрөө ба байгууламж</p>	
<p>98. Эскалаторын машины өрөө</p> <p>99. Эскалаторын татан чангалагчийн өрөө</p> <p>100. Эскалаторын хонгил</p>	<p>Хонгилын эскалаторын цахилгаан хөдөлгүүр, өргөн тээвэрлэх төхөөрөмж, мөн техникийн үйлчилгээний туслах өрөөтэй, дээд давхрын шалны түвшнээс доор байрладаг өрөө</p> <p>Хонгилын эскалаторын татан чангалагч төхөөрөмж, түүний техникийн үйлчилгээний ажилд зориулагдран доод давхарын шалны түвшнээс доор байрладаг өрөө</p> <p>Эскалаторын налуу хэсэг байрлахад зориулагдсан байгууламж</p>

101.Эскалаторын буулгах камер	Хонгилын эскалаторын машины өрөөтэй ойр байрладаг, угсралт ба буулгалтын ажилд зориулагдсан гадагш гардаг тусдаа гарцтай өрөө
Шинэчлэлт, өөрчлөлт	
102.Шинэчлэлт	Эскалаторын аюулгүй, найдвартай ажиллагааг сайжруулах зорилгоор орчин үеийн дүрэм норм, шаардлагын дагуу тоног төхөөрөмжийг шинэчлэн, хийцийг өөрчлөх
103.Өөрчлөлт	Эскалаторын паспортын үзүүлэлтийг өөрчлөн ажиллагааг нь сайжруулахын тулд даацын хийц ба үндсэн элементүүдийг солих буюу дахин хийх

2 дугаар хавсралт

Үзүүлэлтүүд	Тэмдэглэгээ	Хэмжээ
Ердийн хурд(м/с), ихгүй	V	0,78*
Зорчигчдын ачааллаас хамаарахгүй, эскалаторын хөдөлгөөнт тавцангийн хурдатгал (м/с ² , хэтрэхгүй байх)	a _и	0,60
Эхлэх агшинд		
Эрчээ авах явцад		
Зорчигчдын ачааллаас хамаарахгүй, эскалаторын хөдөлгөөнт тавцангийн удаашралт (м/с ² , хэтрэхгүй байх) Үүнд:	a _{тр}	0,60
Ажлын тоормосоор тоормослох үед		1,00
Уруудах хөдөлгөөний үед		
Өгсөх хөдөлгөөний үед		
Эскалаторын тээвэрлэлтийн бүтээл /тооцооны/	П _т _{цаг}	18000BV
Хүн/цаг (хэтрэхгүй байх)		
Хүн/мин (хэтрэхгүй байх)	П _т _{мин}	300BV
Эскалаторын бодит тээвэрлэх бүтээл	П _ф _{цаг}	
Хүн/цаг (хэтрэхгүй байх)		8800 (2.1-V)xVxB
Хүн/мин (хэтрэхгүй байх)	П _ф _{мин}	190 (2.1-V)xVxB

*Аливаа ачаалалгүй байгаа тохиолдолд ецрдийн хурднаас 5% хэтэрч үл болно.

Тэмдэглэл: B – гишгүүрийн өргөн, м.

3 дугаар хавсралт

Эскалаторын үндсэн хэмжээсүүд

Үзүүлэлтүүдийн төрөл	Тэмдэглэгээ (зураг1)	Эскалаторын хэмжээ	
		Давхрын	Хонгилын
Эскалаторын хамгийн их налалтын өнцөг, градусаар	α	35	30
Хөдөлгөөнт тавцангийн гишгүүрийн өргөн. мм	B		1000±10
Ихгүй		1000	
Багагүй		580	
Гишгүүрийн хамгйн бага гүн, мм	L	380	380
Налалтын өнцөг нь 35° байх тохиолдолд дараалсан хоёр гишгүүрийн тавцан хоорондын хамгийн их зай, мм	h	240	-
Налалтын өнцөг нь 30° байр тохиолдолд		250	205
Гишгүүрийн гадаргуугаас барилга, байгууламжийн тааз буюу бусад зориулалтаар доош уншсан саад хүртэлх хамгийн бага зай, мм	h ₁	2300	2300
Эскалаторын харилцан болон шалтай огтлолцох хэсэгт хашлаганаас дээр байрлуулах хамгаалах босоо хаалтны хамгийн бага өндөр, мм	h ₂	250	250
Эскалаторын налуу хэсэг дахь гишгүүрээс бариулын дээд гадаргуу хүртэлх босоо тэнхлэгийн дагуух зай, мм	h ₃	800-1100	800-100
Мөн хэвтээ хэсэг дэх босоо тэнхлэгийн дагуух зай, мм	h ₄	1200	1200
Орох талбай дахь гишгүүрийн хэвтээ хэсгийн хамгийн бага уртын хэмжээ, мм:	I		
6 метрээс илүүгүй өндөрт 0.5м/с ээс ихгүй хурдаар зорчигч тээвэрлэхэд			800
6 метрээс илүү өндөрт 0.5м/с-ээс илүү хурдаар (гэхдээ хонгилын эскалатораар 0.75м7с-ээс ихгүй		1200	1200

хурдаар) зорчигч тээвэрлэхэд			
Шүдэт ирмэгийн огтлолцолын шугамаас (Д цэгээс) бариулын доод төгсгөлд хэвтээ тэнхлэг хүртэлх хамгийн бага зай, мм.	I ₁	300	300
Бариулуудын тэнхлэг хоорондын хамгийн их зай, мм	I ₂	B+400	B+400
Хормойноос хашлага хүртэлх хамгийн их зай, мм	I ₃	120	120
Бариул ба хашлагын хүрээний гадна ирмэг хоорондын хамгийн их зай, мм	I ₄	50	50
Хашлаганы плинтусын хэвтээ тэнхлэгийн чиглэлд хамгийн бага зай, мм	I ₅	30	30
Бариулын амсраас муруйлтын радиусын захын цэг хүртэлх хэвтээ тэнхлэгийн дагуу хамгийн бага зай, мм	I ₆	300	300
Эскалаторын бариулын өргөн, мм	I ₇	70-100	70-100
Бариулын захын ирмэгээс барилгын хана, хонгилын гадаргуу гэх мэт саад хүртэлх хамгийн бага зай, мм	I ₈	80	80
Зэрэцээ байрласан эскалаторуудын бариулуудын захын ирмэгүүдийн хоорондын хамгийн бага зай, мм	I ₈	150	150
Гишгүүрийн гадаргуугийн төвгөрийн өргөн, мм	I ₁₀	2,5-5	2,5-5
Гишгүүрийн гадаргуугийн хотгорын өргөн, мм	I ₁₁	5-7	5-7
Гишгүүрийн гадаргуугийн төвгөрийн хамгийн бага өндөр, мм	h₅	10	10
Орох талбайн шүдэт ирмэгийн шүдний доод гадаргуугаас гишгүүрийн хотгорын ёроол хоорондын зай, мм	b₁	2-8	2-8
Шинээр угсарсны дараа гишгүүр хоорондын хэвтээ тэнхлэгийн дагуу зөвшөөрөгдөх хамгийн их завсар, мм	b₂	6	6
		7	7
Их засварын дараа дээрх зай, мм		10	10
Ашиглалтын үеийн дээрх зай, мм			
Угсралтын үеийн хажуугийн хашлаганы хормой ба			

гишгүүрийн хоорондын хамгийн их зай, мм	b₃	Нэг талаасаа 6, нийтдээ 10	Нэг талаасаа 6, нийтдээ 10
-ашиглалтын үеийн дээрх хэмжээ, хамгийн их, мм		Нэг талдаа 10, нийтдээ 16	Нэг талдаа 10, нийтдээ 16
Доод тахир хэсгээс бусад замын дагуух бариул болон карнизын хоорондох босоо тэнхлэгийн хоорондын зай, мм	b₄	5-с ихгүй байх	5-с ихгүй байх
	b¹₄	25-с багагүй	25-с багагүй
-Доод тахир хэсэг дэх дээрх хэмжээ, мм	b₄	7-оос ихгүй	7-оос ихгүй
	b¹₄	25-аас багагүй	25-аас багагүй
Бариул, түүний амсрын хэвтээ тэнхлэг дэх нүхний ирмэг хоорондын хамгийн их зай, мм	b₅	5	5
	β	40	40
Орох талбайн шүдэт ирмэгийн шүдний налалтын хамгийн их өнцөг, градус			
Хашлаганы плинтусын налалтын хамгийн бага өнцөг, градус	γ	25	25
Орох талбайн түвшингээс бариулын амсар хүртлэх зай, мм	h₆	100-300	100-300
Гишгүүрийн гадаргуугийн төвгөрөөс хашлаганы плинтусийн доод ирмэг хүртлэх босоо тэнхлэгийн дагуух хамгийн бага зай, мм	b₆	25	25

4 дүгээр хавсралт

Эскалаторын тооцооны болон туршилтанд хэрэглэгдэх үндсэн ачааллууд

Тэмдэглэгээ	Ачааллын нэр	Тооцооны төрөл, (үзүүлэлт)	Зангилаа	Томъёо буюу хэмжээ
q_{c1}	Хамгийн их статик H/m^2	Бат бөх байдал	Металл хийц, хучилтын хавтан, орох талбай ба чиглүүлэгчүүд	5000
q_{c2}	Статик H/m^2	Нугаралт	Металл хийц, хучилтын хавтан, орох талбай	4000
q_{c3}	Ашиглалтын хамгийн их H/m	Бат бөх, татах болн дамжуулгын эхлэлтийн үзүүлэлтүүд, тоормолсны үзүүлэлтүүд	Эскалаторын элементүүд (дамжуулга, гинж, тоормос, хөдөлгөөнт тавцан, чиглүүлэгч зам г.м.)	2000(2.1-V)В
q_{ar}^T	Цагийн дундаж ачаалал H/m	Ердийн хүчин чадал	Хонгилын эскалаторын цахилгаан хөдөлгүүр	0.83 $q_{мэ}$
q_{ar}^n	Цагийн дундаж ачаалал H/m	Ердийн хүчин чадал	Давхрын эскалаторын цахилгаан хөдөлгүүр	0.55 $q_{мэ}$
q_{ar}^T	Эквивалент ачаалал H/m	Удаан ажиллах ба тэсвэрлэх чанар,	Хонгилын эскалаторын элементүүд	0.63 $q_{мэ}$
q_{ar}^n	Эквивалент ачаалал H/m	Унаад ажиллах ба тэсвэрлэх чанар	Давхрын эскалаторын элементүүд	0.42 $q_{мэ}$
$q_{цаг}$	Бариул дээр ирэх ачаалал	Сунгалтын бат бөх чанар	Бариул, түүний дамжуулга	0.01 $q_{мэ}$
		Ердийн хүчин чадал		0.01 $q_{мэ}$
		Удаан ажиллах ба тэсвэрлэх чанар		0.01 $q_{мэ}$

5 дугаар хавсралт (загвар*)

... **загварын эскалаторын**

ашиглалтын паспорт

(загвар)

Улсын бүртгэл № _____

Эскалаторыг өөр эзэмшигчид шилжүүлэхэд энэхүү

паспортыг хамт шилжүүлэн өгнө.

Үйлдвэрлэх зөвшөөрөл

20 __ он __ сарын __ № _____

_____ олгов.

_____ үйлдвэрлэгдсэн

(үйлдвэрлэсэн огноо, үйлдвэрлэгчийн нэр болон хаяг.)

_____ үйлдвэрийн дугаар бүхий _____ эскалатор

(загвар)

*- А4 форматын хатуу хавтас

5 дугаар хавсралтын үргэлжлэл

(шинэ хуудас)

1. Эскалаторын техникийн үндсэн үзүүлэлт ба тодорхойлолтууд

- 1.1. Хүн тээвэрлэх бодит хүчин чадал, хүн/цаг _____
- 1.2. Налалтын өнцөг _____
- 1.3. Хөдөлгөөнт тавцангийн шилжилтийн хурд, м/с
Ашиглалтын үед _____
Засварын үед _____
- 1.4. Гишгүүрийн тоо, ш _____
- 1.5. Гишгүүрийн хэмжээ, мм
Өргөн _____
Гүн _____
- 1.6. Засвар кай, мм
- 1.6.1. Гишгүүр хооронд (хамгийн их) _____
- 1.6.2. Гишгүүр, хашлага хооронд (хамгийн их)
а) Нэг талаас _____
б) хоёр талаас нийлбэр нь _____
- 1.6.3. Бариул, хашлага хооронд, (хамгийн их) _____
- 1.6.4. Бариул, амсар дахь нүх хоорондын, (хамгийн их) _____
- 1.7. Бариулын тэнхлэг хоорондын зай, мм (хамгийн их) _____
- 1.8. Хөдөлгөөнт тавцан болон бариулын хөдөлгөөний хурдны ялгаврыг хөдөлгөөнт тавцангийн хурдад харьцуулсан харьцаа _____
- 1.9. Эскалаторын үндсэн голын дамжуулгын төрөл
_____ араат болон гинжит
- 1.10. Тоормосны тодорхойлолт.

Тоормос	Тоо ширхэг	Байрлал	Төрөл /колодкатай, дисктэй г.м/
Хэвийн ажиллагааны			

- 1.11. Цахилгааны гүйдэл ба хүчдэлийн төрөл

Цахилгаан хэлхээний төрөл	Төрөл	Хүчдэл, В
Хүчний		
Удирдлагын		
Засварын гэрэлтүүлэг		
Хэвийн ажиллагааны гэрэлтүүлэг		

- 1.12. Цахилгаан хөдөлгүүрийн үзүүлэлтүүд

Цахилгаан хөдөлгүүр	Хэв загвар	Хүчин чадал, кВт	эргэлтийн тоо, эргэлт/мин
Гол хөтлөгч			
Туслах хөтлөгч			

1.13. Гинжний үзүүлэлтүүд

Гинжний төрөл	Эвдлэх ачаалал, кН	Бат бөхийн нөөцийн итгэлцүүр
Татах		
Дамжуулгын		

*Гинжийг үйлдвэрлэгч байгууллагаас ирүүлсэн баримт бичигт тулгуурлаж бөглөнө.

1.14. Ослоос хамгаалах төхөөрөмжүүд

№	Нэр төрөл	Зориулалт	Ажиллах тохиолдол	Суурилуулалтын тухай мэдээлэл
1	Бариул тасрах, хэт сунах, зогсолтын хориг	Цахилгаан хөдөлгүүрийг унтраана	бариул тасрах, хэт сунах, хурд саарах болон зогсох	
2	Татан чангалах төхөөрөмжийн хориг	Цахилгаан хөдөлгүүрийг унтраана	Татан чангалах төхөөрөмжийн одон араа хөтлөгчийн болон түүний эсрэг зүгт шилжих	
3	Ажлын тоормосны хориг	Цахилгаан хөдөлгүүрийн ажиллагааг зогсооно	Тоормосны колодка тавигдсан, Цахилгаан соронзонгийн якорийн нөөц явалт зөвшөөрөгдөх хэмжээнээс бага болсон тохиолдолд	
4	Орох тавцан ба бариулын амсрын хориг	Цахилгаан хөдөлгүүрийг унтраана.	Орох тавцан дээшлэх тохиолдолд (эскалаторын тэнхлэгийн дагуу), бариулын амсарт гадны биет орсон	
5	«ЗОГС» товчлуур	Цахилгаан хөдөлгүүрийг унтраана.	үйлчлэх ажилчид товчлуур дээр дарсан тохиолдолд	
6	Хашлаган дээрх буюу эскалаторын дэргэдэх “ЗОГС” унтраалга	Цахилгаан хөдөлгүүрийг унтраана.	Унтраалгын товчлуурыг үйлчлэх ажилтнууд болон зорчигчдоос хэн нэг нь дарсан тохиолдолд	
7	Щатны гишгүүрийн өргөлтийн /Доошлолтын/ хориг	Цахилгаан хөдөлгүүрийг унтраана.	Гишгүүрийн доошлох болон дээшлэх хөдөлгөөний үед	

8	бариулын буултын хориг	Цахилгаан хөдөлгүүрийг унтраана.	Доод тахир хэсэгт бариулыг чиглүүлэгчийн хамт салгахад	
9	Гишгүүрийн гүйгчийн хориг	Цахилгаан хөдөлгүүрийг унтраана.	Гишгүүрийн гүйгчүүд чиглүүлэгч замаас мултрахад	
10	Гишгүүрийн хагас голын хориг	Цахилгаан хөдөлгүүрийг унтраана.	Гишгүүрийн үндсэн гүйгчийн хагас гол мултарч, гарсан тохиолдолд	
11	Цахилгааны тэжээлийн хориг	Цахилгаан хөдөлгүүрийг унтраана.	эскалаторыг залгуураар нь цахилгаан тэжээлээс салгахад	
12	Зорчигч унахад ажиллах хориг	Цахилгаан хөдөлгүүрийг унтраана	Дээд доод орох тавцан дээр зорчигч унасан тохиолдолд	
13	Дамжуулгын гинжний хориг	Цахилгаан хөдөлгүүрийг унтраана	Хөтлөгч гинж хэт чангарах	
14	Редукторын голын холхивчийн дулааны реле	Цахилгаан хөдөлгүүрийг унтраана	Холхивч хэт халахад	
15	Гишгүүрийг салгаж авах үеийн хориг	Цахилгаан хөдөлгүүрийг ажиллах болмжийг хаана	Төхөөрөмжийн арал дээш сөхөөтэй байхад	
16	Татах гинжний авютомат тослогчийн хориг	Татах гинжний автомат тослогчийг байрлуулсан тохиолдолд эскалаторын буруу ажиллуулах боломжийг хаана	Автоматыг эскалаторт суурилуулсан тохиолдолд	

Тусгай тэмдэглэл: Эскалаторын зохион бүтээгч байгууллага эскалаторын аюулгүй, удаан хуагцааны ажиллагаанд зориулж дээрх хүснэгтэнд байгаа хамгаалах төхөөрөмжийн нэр төрлийг хяналтын байгууллагатай зөвшилцөн өөрчлөн шинэчилж, нэмж оруулахыг зөвшөөрнө.

5 дугаар хавсралтын үргэлжлэл

(Шинэ нүүрэнд)

2. Иж бүрдэл

Иж бүрдэлд орох зүйлс:

- 2.1. Эскалаторын эд анги, бүрэлдэхүүн хэсгүүд болон эскалаторын захиалгын онцлогтой холбоотой нэмэлт төхөөрөмжүүд _____ (тэмдэглэгээ)
- 2.2. Угсралтын шаардлага, жагсаалтын дагуу багаж, тоноглол, сэлбэг _____ (тэмдэглэгээ)
- 2.3. Ашигалалтын шаардлага, жагсаалтын дагуу багаж, тоноглол, сэлбэг _____ (тэмдэглэгээ)
- 2.4. Ашиглалтын баримт бичгийн жагсаалтын дагуу ашиглалтын баримт бичгүүд _____ (тэмдэглэгээ)
Баглааны (боодлын) байрлал _____ (тоо ширхэг)

(шинэ хуудаснаас)

3. Эскалаторын бүрдэл эд ангиудыг хүлээж авсан гэрчилгээ

- 3.1. _____ үйлдвэрийн дугаар бүхий _____ загварын эскалаторын _____
(бүрдүүлэгч эд ангиудын нэр төрөл тэмдэглэгээ)

“Эскалаторыг төхөөрөмжлөх, аюулгүй ашиглах дүрэм”-ийн дагуу үйлдвэрлэгдэж, техникийн нөхцөлд _____ тохирсон бөгөөд ашиглалтанд тэнцэнэ.

- 3.2. Эскалаторын тулгуур металл хийцийн талаарх мэдээлэл *
(хоёроос доошгүй хуудас)

Нэр төрөл	Үндсэн металл		Нэмэлт металл		Онцгой металл хийцийгхүүлээж авсан акт	
	Хэв загвар	Техникийн нөхцөл, стандарт	Хэв загвар	Техникийн нөхцөл, стандарт	дугаар	огноо

*Үйлвэрлэгч байгууллагаас ирүүлсэн баримт бичгийг үндэслэн бөглөнө.

- 3.3. Онцгой хийц бүтээцийн эд ангиудыг хүлээж авсан гэрчилгээ

Нэр төрөл	тэмдэглэгээ	Бэлдэц			Номер поковки	Дефектоскопийн хяналтын картны дугаар	Механик туршилтын актны дугаар
		Материал		Сертификатын дугаар			
		загвар	УСТ				

5 дугаар хавсралтын үргэлжлэл

4. Эскалаторыг хүлээж авсан гэрчилгээ

Эскалатор нь “Эскалаторыг төхөөрөмжлөх, аюулгүйа жшиглах дүрэм”-ийн шаардлагыг

_____ (Үйлдвэрлэх нэр төрөл, УСТ, MNS... техникийн нөхцөл, техникийн даалгавар)

_____ хангаж энэхүү паспортын дагуу хүлээн авах туршилтын дараа ашиглахыг зөвшөөрөв.

Үйлдвэрлэсэн огноо: _____

Үйлдвэрлэгч байгууллагын

Ерөнхий инженер:

(гарын үсэг, огноо)

Техникийн хяналтын хэлтсийн дарга:

(гарын үсэг, огноо)

Тамга

5. Баталгаат засварын үүрэг

5.1. Үйлдвэрлэгч байгууллагын баталгаат засварын үүрэг

_____ (Үйлдвэрлэгч байгууллагын нэр)

нь ашиглалт, угсралт, хадгалалт болон тээвэрлэлтийн горим зөрчигдөөгүй тохиолдолд эскалаторыг зохиогчийн зураг төслийн дагуу үйлдвэрлэгдсэн болохыг баталж байна.

Эскалаторын ажиллагааны баталгаат хугацаа _____ ашиглаж

(сар, жил)

орсон өдрөөс эхэлнэ.

Үйлдвэрлэгч байгууллагын ерөнхий инженер: _____

Үйлдвэрлэгч байгууллагын Техникийн хяналтын хэлтсийн дарга: _____

Тамга

(огноо)

5.2. Эскалаторыг угсрагч байгууллагын баталгаат хугацааны үүрэг

_____ нь

(Эскалаторыг угсарсан байгуулаган нэр)

эзэмшигч байгууллага ашиглалтын горимыг зөрчөөгүй тохиолдолд эскалаторын угсралтын болон хэвийн ажиллагааны талаарх техникийн бүх норм, зааврын дагуу угсарсан болохыг баталж байна.

Эскалаторын ажиллагааны баталгаат хугацаа _____ өдрөөс буюу

(сар жил)

Эскалаторыг техникийн бэлэн байдалд орсон буюу ашиглалтанд хүлээлгэн өгсөн өдрөөс эхэлнэ.

Угсрагч байгууллагын ерөнхий инженер: _____

Тамга

(огноо)

6. Суурилуулсан тухай гэрчилгээ

_____ үйлдвэрийн дугаар бүхий _____ загварын эскалатор

(загвар)

нь “Эскалаторыг төхөөрөмжлөх, аюулгүй ашиглах дүрэм” болон _____

(угсралтыг гүйцэтгэхэд мөрдөж баримтласан баримт бичгүүдийн нэр төрлийг бичнэ.)
-ийн шаардлагын дагуу угсрагдсан болно.

Угсрагч байгууллагыг

төлөөлж: _____

(албан тушаал, гарын үсэг)

Тамга

Ашиглагч багууллагыг

төлөөлж: _____

(албан тушаал, гарын үсэг)

Тамга

5 дугаар хавсралтын үргэлжлэл

(шинэ хуудаснаас)

7. Зүгшрүүлэлт хийсэн тухай гэрчилгээ

_____ үйлдвэрийн дугаар бүхий _____ загварын эскалатор
(загвар)

_____ цагийн туршид ерөнхий дамжуулгаар нь дээш болон доош чиглэлд Зүгшрүүлэлтийн үр дүнд эскалаторыг ашиглаж болно гэж дүгнэв.

Угсрагч байгууллагыг

төлөөлж: _____

(албан тушаал, гарын үсэг)

Тамга

Ашиглагч багууллагыг

төлөөлж: _____

(албан тушаал, гарын үсэг)

Тамга

20 __ оны __ сарын __ өдөр

(шинэ хуудаснаас)

8. Эскалаторын ашиглалтын хяналт хариуцагч, бүрэн бүтэн байдал ба аюулгүй ажиллагааг хариуцагчийн талаарх мэдээлэл

(хоёроос доошгүй хуудас байна)

Томилсон тушаалын огноо ба дугаар	Албан тушаал, овог нэр	Эскалаторын ажиллагаа, дүрмийн мэдлэгийн түвшинг тогтоосон огноо	Хариуцсан этгээдийн гарын үсэг

5 дугаар хавсралтын үргэлжлэл

(шинэ хуудаснаас)

9. Эскалаторын эд ангиудад үйлдвэрлэлт, угсралт, засвар, ашиглалтын явцад хийцийн өөрчлөлт хийсэн тухай тэмдэглэл

(гурваас доошгүй хуудас байна)

Үндэслэл (бичиг баримтын нэр төрөл)	Хийгдсэн ажлын агуулга	Хийгдсэн ажлын дараах эскалаторын ажиллагааны талаарх тодорхойлолт	Өөрчлөлт хийсэн хариуцалагатай этгээдийн албан тушаал, овог нэр	Тайлбар

10. Магадлал хийсэн тухай тэмдэглэл

(арван таваас доошгүй хуудас байна)

Огноо	Магадлалын үр дүн	Дараагийн магадлал хийх хугацаа

5 дугаар хавсралтын төгсгөл

11. Бүртгэл

Эскалатор нь _____ дугаараар _____ -д бүртгэгдэв.

(бүртгэж авсан байгууллагын нэр)

Паспортонд дугаарлагдсан _____ хуудас

Нийт үдсэн _____ хуудас

Түүний дотор зураг төсөл _____ хуудас

(Бүртгэл авсан хүний албан тушаал)

(гарын үсэг)

20 __ оны __ сарын __ өдөр.

Тайлбар: эскалаторын паспорт нь доорх зүйлүүдийг агуулсан байна. Үүнд:

1. Техникийн үндсэн үзүүлэлтүүд
2. Иж бүрдлийн гэрчилгээ
3. Эскалаторын бүрдэл эд ангиудыг хүлээж авсан гэрчилгээ
4. Эскалаторыг хүлээж авсан гэрчилгээ
5. Баталгаат засварын үүрэг
6. Суурилуулсан тухай гэрчилгээ
7. Эскалаторт зүгшрүүлэлт хийсэн гэрчилгээ
8. Эскалаторын ашиглалтын хяналт хариуцагч, бүрэн бүтэн байдал ба аюулгүй ажиллагааг хариуцагч
9. Эскалаторын эд ангиудад үйлдвэрлэлт, угсралт, засвар, ашиглалтын явцад хийцийн өөрчлөлт хийсэн тухай тэмдэглэл
10. Эскалаторт магадлал хийсэн тухай тэмдэглэл
11. Бүртгэлийн тухай мэдээллүүд

Паспортанд байх хавсралтууд:

- а. Дан болон цоцолбор эскалаторын оврын хэмжээ, зураг.
- б. Эскалаторын дамжуулгын цахилгааны удирдлагын зарчмын схем, элементүүдийн жагсаалт.
- в. Эскалатор нь “Эскалаторыг төхөөрөмжлөх, аюулгүй ашиглах дүрэм” -ийн дагуу угсрагдаж, хүлээн авах, хүлээлгэн өгөх туршилт шалгалт хийгдсэн, ашиглалтанд тэнцсэнийг гэрчлэх акт.

Эскалаторын техникийн бэлэн

байдлын акт

_____ хот. 20__ оны __ сарын __ өдөр

Энэхүү баримтыг _____ нь

(албан тушаал, овог нэрс)

_____ байгууллагыг төлөөлж _____

(угсрагч байгууллагын нэр)

_____ -ийн _____ (зөвшөөрөл олгосон байгууллага
этгээдийн нэр) (он/сар/өдөр)

№ _____ зөвшөөрөл олгосон _____

(эрх бүхий этгээдийн овог нэр албан тушаал)

Барилгын ерөнхий гүйцэтгэгч _____

(Байгууллагын нэр, албан тушаал, овог нэр)

нар хамтран _____ үйлдвэрийн дугаар бүхий _____

загварын эскалатор болон түүний _____

(бүрдэл, эд ангиудын нэр төрөл)

_____ бүрдэл, эд ангиудад үйлдвэрлэгчийн гаргасан баримт бичгийн дагуу угсралт, тохиргоо, үйлчилгээний ажлууд хийгдэж дууссан болно. Эскалаторыг суурилуулсан хаяг:

Эскалатор ба түүний бүрэлдэхүүн хэсгүүдэд үзлэг шалгалт, туршилт магадлал хийхэд бүрэн бүтэн тэнцсэн тул ашиглалтанд хүлээж авахад бэлэн байна.

Угсралтын байгууллагын төлөөлөгч _____

(гарын үсэг)

(Овог нэр)

Барилгын ерөнхий гүйцэтгэгч

байгууллагын төлөөлөгч _____

(гарын үсэг)

(Овог нэр)

Эскалаторыг ашиглалтанд хүлээж авах акт

_____ хот/аймаг 20__ оны __ сарын __ өдөр

Угсарч бэлэн болсон эскалаторыг хүлээж авах комиссын бүрэлдэхүүн: эскалаторыг зээмшигч байгууллагыг төлөөлж: _____

(байгууллагын нэр) (албан тушаал, овог нэр)

захиалагч байгууллагыг төлөөлж: _____

(байгууллагын нэр) (албан тушаал, овог нэр)

угсрагч байгууллагыг төлөөлж: (шинэчлэлт өөрчлөлт хийсэн) _____

(байгууллагын нэр) (албан тушаал, овог нэр)

барилгын ерөнхий гүйцэтгэгч байгууллагыг төлөөлж: _____

(байгууллагын нэр) (албан тушаал, овог нэр)

эскалаторын бүрэн бүтэн ба ашиглалтын аюулгүй байдал хариуцагчийг төлөөлж:

(байгууллагын нэр) (албан тушаал, овог нэр)

улсын хяналтын байгууллагыг төлөөлж: _____

(байгууллагын нэр) (албан тушаал, овог нэр)

нар “Эскалаторыг төхөөрөмжлөх, аюулгүй ашиглах дүрэм”-ийн дагуу ирүүлсэн баримт бичиг, эскалатор, түүний бүрэлдэхүүн хэсгүүдэд үзлэг шалгалтын дүнг үндэслэн энэхүү актыг гаргав.

Эскалаторыг суурилуулсан хаяг: _____

Үзлэг шалгалтаар барилга, эскалаторын угсралт, тохирпээны

ажлуудыг: _____

(техникийн нөхцөл)

“Эскалаторыг төхөөрөмжлөх, аюулгүй ашиглах дүрэм”-ийн дагуу хийжээ. Үүнд: эскалатор нь дүрмийн шаардлага ба паспорт, техникийн баримт бичигтэй тохирч байна.

эскалатор нь техникийн бэлэн байдалтай байгаа ба ашиглалтын аюулгүй байдлыг хангана.

эскалатор ашиглалтын нөхцөл нь дүрмийн шаардлагыг хангана.

Эскалаторыг эзэмшигч болон бүрэн бүтэн ба ашиглалтын аюулгүй байдлыг хариуцагч нар ашиглалтанд хүлээн авав.

Эскалаторыг хүлээлгэн өгсөн:

угсрагч байгууллагыг төлөөлж: _____

(байгууллагын нэр) (албан тушаал, овог нэр)

барилгын ерөнхий гүйцэтгэгч байгууллагыг төлөөлж: _____

(байгууллагын нэр) (албан тушаал, овог нэр)

захиалагч байгууллагыг төлөөлж: _____

(байгууллагын нэр) (албан тушаал, овог нэр)

Эскалаторыг хүлээж авсан:

Эскалаторыг эзэмшигч байгууллагыг төлөөлж: _____

(байгууллагын нэр) (албан тушаал, овог нэр)

Эскалаторын бүрэн бүтэн ба аюулгүй байдал хариуцагчийг төлөөлж:

(байгууллагын нэр) (албан тушаал, овог нэр)

Комиссын дарга: _____

(байгууллагын нэр) (албан тушаал, овог нэр)

Мэргэжлийн хяналтын байгууллагыг төлөөлж: _____

(байгууллагын нэр) (албан тушаал, овог нэр)

8 дугаар хавсралт

Эскалаторын ашиглалтын хяналт

хариуцагчийн үндсэн үүрэг

Эскалаторын ашиглалтын хяналт хариуцагч нь дараах үүргийг хүлээнэ. Үүнд:

- эскалаторын техникийн болон аюулгүй ажиллагааны байдалд хяналт тавих;
- техникийн магадлал хийх ажилд оролцох;
- эскалаторын техникийн үйлчилгээний графикийн биелэлтэнд хяналт тавих;
- үйлчлэх ажилтнууд болон мэргэжилтнүүдийг энэхүү дүрэм болон үйлдвэрлэлийн зааварчилгаагаар хангах, биелэлтэнд хяналт тавих;
- үйлчилгээний ажилтнуудын дунд тогтоосон журмуудын биелэлтэнд хяналт тавих;
- тогтоогдсон цаг хугацаанд үйлчилгээний ажилтнуудаас мэдлэгийн түвшин тогтоох шалгалт авах;
- Мэргэмшийн хяналтын болон мэргэжлийн байгууллагуудаас /зөвлөх үйлчилгээ үзүүлэгч/ гаргасан акт, дүгнэлт, албан шаардлага, зааварчилгаа, зөвлөмжийн биелэлтэд хяналт тавих;
- байгууллага дээр тогтсон машины болон татан чангалах төхөөрөмжийн өрөөний түлхүүрийг хадгалах, олгох журмыг хянах;
- эскалатор нь осолд хүргэж болохуйц техникийн гэмтэлтэй, эсвэл аттестатчилагдсан үйлчилгээний ажилтнууд байхгүй тохиолдолд ажиллагааг зогсооно.

Эскалаторын бүрэн бүтэн байдал ба аюулгүй ажиллагааг

хариуцагчийн үндсэн үүрэг

Бүрэн бүтэн байдал ба аюулгүй ажиллагааг хариуцагч нь доорх үүргийг хүлээнэ. Үүнд:

- найдвартай, аюул осолгүй, урт хугацаанд зорчигч тээвэрлэх боломжийг хангах;
- эскалаторт засвар, техникийн үйлчилгээ хийгдэх үед үйлчлэх ажилтнуудын ажлыг зохион байгуулах;
- Норм, нормативын баримт бичигт тавигдсан шаардлагын дагуу хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааг зохион байгуулах;
- эскалаторын засвар, техникийн үйлчилгээг цаг тухайд нь хийлгэж хийгдсэн ажлуудын чанарыг шалгаж байх;
- эскалаторын техникийн үйлчилгээ болон тохиргооны ажлуудад биечлэн оролцох;
- эскалаторыг техникийн магадлалд оруулах, техникийн магадлал хийгдэх үед биечлэн байлцах;
- эскалаторын техникийн паспорт болон холбогдох бусад баримт бичгийн хадгалалтыг хариуцаж, шаардлагатай өөрчлөлтүүдийг нэмж тэмдэглэж байх;
- эскалаторын удирдлага, үйлчилгээний ажилд аттестатчилагдсан ажилтнуудаас бусад ажилтнуудыг оролцуулахгүй байх;
- үйлчлэх ажилтнуудыг үйлдвэрлэлийн болон хөдөлмөр хамгааллын зааварчилгаагаар хангах;
- үйлчлэх ажилтнуудын мэдлэгийн түвшинг цаг тухайд нь шалгаж байх;
- үйлчлэх ажилтнуудын мэдлэгийн түвшинг дээшлүүлэх ажлыг зохион байгуулах;
- мэргэжлийн хяналтын болон мэргэжлийн байгууллагуудын /зөвлөх үйлчилгээ үзүүлэгч/ гаргасан акт, дүгнэлт, албан шаардлага, зааварчилгаа, зөвлөгөөг цаг тухайд нь биелүүлэх ажлыг зохион байгуулах;
- техникийн болон татан чангалах төхөөрөмжийн өрөөний хаалгуудыг байнга цоожтой, орчин тойрныг гэрэлтэй чөлөөтэй байлгах, түүнд хяналт тавих;
- Эскалатор нь осолд хүргэж болохуйц техникийн гэмтэлтэй, эсвэл аттестатчилагдсан үйлчилгээний ажилтнууд байхгүй тохиолдолд ажиллагааг зогсоох;
- хариуцсан ажилтнууддаа өдөр тутам тэдний ажил үүрэгтэй нь холбогдсон зааварчилгаа өгнө.